

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчдэд

Дэлхийн олон нийт хүлээн зөвшөөрсөн Эмнести Интернэшнл хүний эрхийн олон улсын байгууллагын үйл ажиллагаанд бид нэгдэн орсноос хойш 10 гаруй жилийн нүүр үзэж байна.

Дэлхий даяар явуулж байгаа олон улсын кампанит ажил болон дотоодод хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн тухай боловсрол мэдлэгийг дээшлүүлэх үйлсэд хамтран ажилласан та бүхэндээ гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

2006 он ажил үйлсээр дүүрэн, Монголыг Эмнести Интернэшнл нэр хүндээ дээшлүүлж, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлсэн жил байлаа. 2007 он түүнээс дутахааргүй байна гэдэгт итгэл төгс байна.

Хүний эрхийн төлөө ариун үйлсэд нэгдэж, хамтран зүтгэж байгаа та бүхэндээ эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөж байна.

Академич С. Нарангэрэл Удирдах зөвлөлийн дарга



С. Эрдэнэ, олон улсын эрх зүйч мэргэжилтэй, Монголын Эмнести Интернэшнлийн дэд дарга



С.Ганчимэг, Монгол энэтхэгийн хамтарсан сургуулийн сургалтийн менежер, Монголын Эмнести Интернэшнлийн Багш нарын бүлгийн ахлагч, Хүний эрхийн боловсрол хариуцсан Удирдах зөвлөлийн гишүүн



Р. Оюунбадам, гавъяат хуульч, ШШБЕГ-ын харьяа Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга, Гишүүнчлэл хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн



Ц.Оюунбаатар, Улсын их хурлын гишүүн асан. Консенсус төвийн тэргүүн. Монголын Эмнести Интернэшнлийн Парламентчдын бүлгийн ахлагч, Кампанит ажил хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн



Ш. Анхмаа, Цагаан лавай дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, Монголын Эмнести Интернэшнлийн Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч, Мэдээлэл хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн,



П.Тодрол, МУИС-ын эдийн засгийн 1-р дамжааны оюутан, Монголын Эмнести Интернэшнлийн Оюутан тэмцэгч сүлжээний ахлагч, Залуучуудын асуудал хариуцсан Удирдах зөвлөлийн гишүүн



Б.Энхтуяа, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан, өмгөөлөгч, нотариатч Монголын Эмнести Интернэшнлийн Хуульчдын бүлгийн ахлагч, Сан арвижуулалт хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн



П.Жаргал, Ийгл телевизийн орчуулагч, редактор. Идэвхжилт хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн

2006 онд Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөл ээлжит хурал 11 удаа, ээлжит бус хурлыг 1 удаа нийтдээ 12 удаа хуралдаж, байгууллагын үйл ажиллагаа болон стратеги төлөвлөгөө, төсөв, төрөл бүрийн тайлан илтгэл, байгууллагын чадавхи болон дотоод үнэлгээ, зарим холбогдох дүрэм журмуудыг боловсруулж, батлах, олон улсын хурлын төлөөлөгчдийг сонгох гэх мэт маш олон асуудлаар шийдвэр гаргаж ажилласан байна. Удирдах зөвлөлийн гишүүн П.Тодрол Турк улсад суралцах болсоны улмаас Багануур дүүргийн бүлгийн ахлагч, Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар барилга хот тохижилт, дэд бүтэц, аялал жуулчлал хариуцсан түшмэл Д.Эрдэнэчимэг МЭИ-ийн дүрмийн дагуу Удирдах зөвлөлийн гишүүнээр нөхөн сонгогдлоо.



ТАНИЛЦУУЛГА

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн талаархи танилцуулга



Байгалийн гамшигт өртөөгүй хэрнээ хүмүүс өлсгөлөн, халдварт өвчинд нэрвэгдэн, орон гэргүй болж, ядуурсаар байгаа билээ. Тэгвэл улс орнуудын засгийн газрууд хүний хөдөлмөрлөх, сурч боловсрох, хүрч болох дээд түвшинд эрүүл байх, зохистой орон гэрээр хангагдах, аюулгүй эрүүл хоол хүнс болон ундны цэвэр усаар хангагдах эрхийг хамгаалах, хүндэтгэх, зөрчихгүй байх үүрэг хүлээдэгийг энэхүү танилцуулгаас мэдэж болно.

Хүйсийн тэгш эрхийн талаархи танилцуулга




Хүйсийн тэгш эрхийн үндсэн дээр ямар нэгэн хүчирхийлэлгүй адил тэгш байх эрхийг дэмжих, эмэгтэйчүүдийн эсрэг алагчилах бүх хэлбэрийг устгах, өргөн тархсан эрх

ямба, хүнд суртлын эсрэг тэмцэх, тоо тоймшгүй олон хүний эрхийн зөрчлүүдийг үр дүнтэйгээр шийдвэрлэх, шударга ёсны шүүхэд аваачихад дэмжлэг үзүүлэх ялангуяа эмэгтэйчүүдийг алагчилах үзлийн эсрэг, бэлгийн өөр чиг хандлагын зөрчил, жендерийн ялгаварлан гадуурхалтын хохирогчдыг хамгаалах, дэмжихэд чиглэгдсэн төслүүдийг голлон хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга замыг энэхүү танилцуулгаас мэдэж болно.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрхийн талаархи танилцуулга

Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд нь хүн бүрийг хүрч болох бололцоот түвшинд эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, тэдний эрхийг үр дүнтэйгээр дэмжих, БЗХӨ болоод хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах, шаардлагатай хоол хүнсээр хангах зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг дэмжин ажилладаг. Мөн гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг сэтгэл зүйн болон шаардлагатай эмнэлгийн үйлчилгээнд хамруулах, сайжруулахын төлөө кампанит ажлуудыг өрнүүлэх үедээ улс орны уламжлал, ёс зүйг зөрчсөн гэх шалтгаанаар байнга заналхийлэл, дарамт шахалттай тулгарч байгааг энэхүү танилцуулгаас мэдэж болно.



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ЦАГ БОЛОН МЭДЛЭГЭЭ ХАНДИВЛАГЧ САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

Монголын Эмнести Интернэшнлийн Сайн дурынхан нь ЭИ-ийн сургалт, кампанит ажил зохион байгуулах, холбогдох мэдээллийг орчуулах, түүнийг түгээх, кампанит ажлын сурталчилгаа, тараах материалыг хийх, гишүүд дэмжигчидтэй харилцахад өөрийн цаг хугацаа, мэдлэгээ үнэ хөлсгүй зориулдаг гишүүд, дэмжигчид юм.


Бедия Акьюз



Герман улсын иргэн Бедия Акьюз МЭИ-д 2005 оны 10 дугаар сараас 2006 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд Захидал уриалга бичих болон хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд оролцлоо. Долоо хоногт нэг өдрийг захидал уриалга бичиж явуулахад зарцуулж байлаа. Үүнээс гадна

МУИС болон Хэл Иргэншлийн дээд сургуулийн оюутнуудад хүний эрхийн талаархи хичээлийг англи хэл дээр зохион байгуулсан юм. Мөн залуучуудад зориулсан уулзалт, концертод сан арвижуулах, туршлага солилцох зэргээр хувь нэмэрээ оруулж байв. Яаралтай үйл ажиллагааны сүлжээний дагуу захидал хэрхэн бичих тухай сургалтыг залуучуудын бүлгийн 3 гишүүнд явуулснаас оролцогчид одоо ч сайн дураараа үйл ажиллагаанд идэвхитэй оролцсоор байна.

Хедия Акьюз



Бедиагийн дүү Хедия мөн Монголд 2006 оны 6-8 сард байх хугацаандаа долоо хоногийн 3 өдрийг яаралтай үйл ажиллагааны сүлжээний дагуу захидал уриалга бичихэд зориулж байв. Энэ хугацаанд долоо хоногт 3-4 захидал бичиж илгээж байсан юм. Чөлөөт цагаараа залуучуудын бүлгийнхэнтэй туршлага солилцож байлаа.

Клаудия Огунеми



Их Британийн иргэн Клаудия 2005 оны 8 дугаар сараас 2006 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд яаралтай үйл ажиллагааны сүлжээний дагуу захидал бичсэн юм. Долоо хоногийн 3 өдөрт 15.00-17.00 цагт ажиллаж байв. МЭИ-д ажиллаж байгаа сэтгэгдлээ Яаралтай үйл ажиллагааны сүлжээний электрон сонинд нийтлүүлсэн байна.

2006 онд Монголын Эмнести Интернэшнл дээр гадаадын 3, монголын 12 нийт 16 сайн дурын ажилтан ажиллаа.

The view from AI Mongolia

Claudia Ogunyemi, the new UA coordinator at AI Mongolia, tells us a little about her work in Ulaan Baatar, over 6,000 miles from the IS in London.

"It was with excitement (and perhaps a bit of trepidation) that I came to Ulaan Baatar, Mongolia in August with my husband and son from Kent, England where we live. His assignment is for a year and I looked forward to working with an organisation where I could contribute and learn.

"I first learned about Amnesty International after I signed my name to a petition against the use of blood diamonds in African countries, particularly in Sierra Leone. I remember seeing names from around the world and thinking how powerful a tool it was for promoting awareness and taking action. Since then, I have signed my name to many other petitions that I have received.

"My role at AI Mongolia is primarily as UA Coordinator, but I will also help out in areas such as campaigning, fundraising and financial management; putting to use my finance and accounting background. AI Mongolia's UA network is still in its infancy, mostly due to the language barrier. As English is not widely spoken in this developing country, it means that translating the UAs can be a time-consuming task. However, with the help of native English speakers who volunteer we have been able to send out appeals quickly.

"With the help of my Mongolian colleagues, we hope to increase our UA network by setting up a system whereby our student and youth members will help to translate UAs as soon as we receive them. As they are studying English in school, translation should not be as time-consuming an operation. With this translation team in place, we will be in a better position to establish a stronger network so that English-speaking volunteers are not required to respond to the very important UA appeals.

"So far, I am well on my way to fulfilling my two goals of contributing and learning. As part of the UA network I am able to use my voice by putting 'pen to paper' and speaking out on various human rights abuses worldwide. It's made me think in a new way and I've made use of the various publications if the office to learn more about what human rights mean in my life and how I might promote them to others every day.

Эдийн засаг нийгэм соёлын эрхтэй холбогдох баримт бичиг материалууд

Аливаа улсын засгийн газар хүний эрхийг хүндэтгэн хамгаалахад эн тэргүүнд хариуцлага хүлээх нь зайлшгүй. Гэхдээ компаниуд ч олон улсын хуулийн дагуу хүний эрхийг хамгаалахад хариуцлага хүлээх бөгөөд засгийн газараас хүний эрхийг зөрчөөл дэмжихгүй байх болон хамтран оролцохгүй байх үүрэгтэй байдаг. Хүний хэрэгцээ шаардлага дээр тулгуурлан бичэсн эрхэлж ашиг олдог компани пүүсийн ажилтан албан хаагчдад зорилусан сургалтанд зориулсан эл гарын авлагад Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг нийгэм соёлын эрхийг хамгаалж буй үндэсний болон бүс нутаг, олон улсын туршлага, Аюулгүйн старт ба түүний хэрэгжилт илтгэлүүд, Хүний эрхтэй холбоотой асуулт хариулт зэрэг өргөн хүний ойлголт, баримт бичгүүдийг багтаасан эмхтгэл юм.

Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Түүх



Хүний эрхийн асуудлыг сургалтын хөтөлбөрт оруулж, түүхийн хичээлээр заахаар тусгасан энэ ном нь түүхийн ангид хүний эрх болоод иргэний эрхийн талаар заах, энэ чиглэлээр судалгаа хийдэг хүмүүст чухал гарын авлага болсон юм. Энэ ном нь хүний эрх Сургалтын хөтөлбөрт гэдэг цувралуудын нэг бөгөөд багш, сурган

хүмүүжүүлэгчид, хүний эрхийн боловсрол болон энэ чиглэлээр ажилладаг салбарын хүмүүст зориулсан юм.

Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Математик



Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт иргэншлийн хичээлийн эзлэх байр суурь улам бүр өсөн нэмэгдэж байна. Түүх, Газар зүй, Шашны боловсрол, Гадаад хэл зэрэг хичээлийн агуулгад хүний эрхийн чиглэлээрх асуудлууд гарч ирэхэд багш нар ерөөсөө гайхахаа больсон билээ. Гэвч хүний эрхийн

асуудлыг математикийн хичээлтэй хамруулан ойлгох талаар учир дутагдалтай хэвээр байна. Хүний эрх сургалтын Хөтөлбөрт: Математик ном нь хүний

эрхийг математикийн хичээлд нэгтгэж өгснөөрөө энэ ойлголтыг таягдан хаяхад чухал алхам болж өглөө.

Хүний эрхийн шинэ тактик цахим ном

Энэхүү гарын авлага бол хүний эрхийн ажил дахь тактикийн өргөн боломж бололцоонуудыг нээн үзүүлэхийн тулд Хүний Эрхийн Шинэ Тактик Төслөөс эмхлэн гаргасан олон номуудын нэг юм. Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төвөөс хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага, хувь хүмүүсийн бүтээлч туршлага, тэдэнд тохиолдсон бэрхшээл зовлон, амжилт бүтээл дээр суурилан гаргасан Тактикийн тэмдэглэл, www.newtactics.org цахим хуудаснаас болон Хүний эрхийн гинэ тактик номуудаас түүвэрлэн авсан ялангуяа Монгол улсад хэрэглэж болохуйц шинэлэг тактикуудыг урьдчилан сэргийлэх тактик, эсэргүүцэх тактик гэх мэтээр сэдэвлэн, түүвэрлэн орчуулсан уг номыг PDF файл хэлбэрээр www.amnesty.mn хуудаснаа байрлуулан олны хүртээл болгож байна.

Хорих, цагдах хорих газарт хийх мониторинг: ТББ-уудад зориулсан гарын авлага



Хүний эрхийн үүднээс авч үзвэл хорих, цагдан хорих газар бол хүний эрхийг зөрчих ноцтой аюул оршиж байдаг нилээд хүндрэлтэй байгууллага юм. Ардчилсан нийгэмд дээрх газруудыг өөрчлөн шинэчлэх асуудал тухайн чиглэлээр ажилладаг мэргэжлийн хүмүүс төдийгүй иргэний

нийгмийг бүхэлд нь сэтгэл зовоосон асуудал байдаг. Улс орнуудад Омбудсмен, Парламентын комиссууд, мэргэшлийн байгууллагууд зэрэг хараат бус янз бүрийн байгууллага, зүтгэлтнүүд хорих, цагдан хорих газрыг урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгах эрхтэй байдаг боловч энэ үйл хэрэгт иргэдийн нийгмийн төлөөлөгчид болон ТББ-ууд хяналтын үнэлж баршгүй хувь нэмэр оруулж болохыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Удирдамжийн шинжтэй эл гарын авлага Монгол улс дахь албадан саатуулах ба хорих газруудад хүний эрхийг хамгаалах, энэ үйлсэд иргэний нийгмийн төлөөллийг идэвхтэй оролцуулахад үнэлж баршгүй тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял илтгэл

Уг илтгэл нь Монгол улс дахь хүний амьд явах эрх ба түүний баталгаа, Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглсэн байдлын судалгаа Цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл, Монгол улсын дагаж



Б.Мөнхжавхлан.

• Философич мэргэжилтэй. МУИС-д цагийн багшаар ажиллаж байна. 2002 онд Эмнести Интернэшнлийн гишүүн болсон. Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн. Эмнести Интернэшнлд сүүлийн 3 жил сайн дурын ажилтнаар ажиллаж байгаа.

2006 оны 6 дугаар сард Энэтхэг улсын Хайдарабадын Их сургуульд магистр хамгаалж ирсний дараа буюу энэ оны сүүлийн хагасын байдлаар дараах ажлуудад оролцоод байна.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийг таслан зогсооё илтгэл ба кино хэлэлцүүлэг явуулах бэлтгэл ажлуудад оролцсон
- Сар бүр Эмнести Интернэшнлээс эрхлэн гаргадаг Wire сонин бичиг, болон зарим шаардлагатай кампанит ажлын талаарх мэдээллүүдийг орчуулах, хянаж, редакторлах
- Эмнести Интернэшнлээс гаргаж буй зарим ном товхимолын техник редакторын ажлуудыг хийж гүйцэтгэх зэргээр гадна 7 хоногт 2-оос доошгүй цаг болон өөрийн мэдлэгээ Эмнести Интернэшнлд хандивладаг.

М. Гэрэлмаа

• МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн Эрх зүйн 2 дугаар курсын оюутан. 2006 оны 4 дүгээр сард гишүүнээр элссэнээс хойш байгууллага дээр долоо хоногт 4 цагаар ажиллаж энэ хугацаандаа сургалтын болон орчуулгын материалыг компьютер дээр шивэх, хувилах, "Сая Сая дүр төрх" аяныг өөрийн сургууль

дээрээ, Эмэгтэйчүүдийн эрхийн талаархи кино хэлэлцүүлэг, Эмнести Интернэшнлийг танилцуулах, залуучуудын бүлгийн ахлагч сонгох хурлын бэлтгэл хангах, үйл ажиллагааг зохион байгуулах, "Эрхийнхээ төлөө шуугицгаая" тоглолт, Дарфурын төлөө өдөр, Энх тайвны өдөр, Олон улсын хүний эрхийн өдөр, Цаазаар авах ялын эсрэг өдрөөр гарын үсэг зуруулах, Эмнести таниулах ажлын бэлтгэлийг хангах, МУИС-ийн оюутны эрх ашгийг хамгаалах нийгэмлэг" - тэй хамтран "Оюутны эрх" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах үйл ажиллагаанд биечлэн оролцсон.

ДАДЛАГЫН ОЮУТНУУД

Монголын Эмнести Интернэшнл байгууллагад Монгол улсын их дээд сургуулиудаас төгсөх ангийн оюутнууд мэргэжлийн дадлага ажлыг хийдэг. Энэ нь байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, зохион байгуулж буй ажилд хамтран оролцох мөн кампанит ажлуудыг зохион явуулдаг юм. Энэ удаад МУИС-ын ОУХДС-ын оюутан Б.Солонго Б.Мөнгөнзаяа. Б.Цэцэгжаргал А.Цэрэндорж Б.Хишигжаргал нар нийт 45 хоног дадлага хийлээ.

З.Балдорж

• ШУТИС-ийн Компьютер Дизайны ангийн хоёрдугаар курсын оюутан. МЭИ-ийн кампанит ажилд сурагч байхаасаа оролцож байсан. Одоо байгууллага дээр долоо хоногт 5 цагаар ажиллаж сургалт, кампанит ажлын самбар, тараах материалын загвар гаргаж, хэвлүүлэх, тоног төхөөрөмжийн

засвар, залуучуудтай харилцаа холбоо тогтоох зэрэгт хувь нэмэрээ оруулж байдаг юм. Хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудаас дурдвал залуучуудын бүлгийн болон Хүний Эрхийн боловсролын сургалтуудад цэрэг хүүхдүүдийн төлөө цаасан шувуу хийхийг заах, "Сая сая дүр төрх" аяны хүрээнд зураг авах, НҮБ-д гардуулах самбар бэлдэх, "Эрхийнхээ төлөө шуугицгаая", Дарфурын төлөө" Цэнхэр малгайтнууд" аян, Японы дайны үеэр бэлгийн боолчлолд өртсөн эмэгтэйчүүдийн төлөөх кампанит ажил, Цаазаар авах ялын эсрэг өдөр, Хүний эрхийн өдрөөр үзүүлэн тараах материал бэлдэх ажилд оролцож захидал уриалгад гарын үсэг цуглуулах ажилд оролцсон юм.

А.Дөлгөөн

• Монгол Энэтхэгийн хамтарсан сургуулийн 11 дүгээр ангийн сурагч. Долоо хоногт 2 цагийг МЭИ-д зориулж байгаа бөгөөд энэ хугацаандаа сонин бичиг, захидал түгээх, яаралтай үйл ажиллагааны дагуу захидал бичих, кампанит ажлын материалыг англиас монгол хэл рүү орчуулах ажилд хувь нэмэрээ

оруулж байна. "Эрхийнхээ төлөө шуугицгаая", "Дарфурын төлөө" Цэнхэр малгайтнууд" аян, Японы дайны үеэр бэлгийн боолчлолд өртсөн эмэгтэйчүүдийн төлөөх кампанит ажил, Цаазаар авах ялын эсрэг өдөр, Хүний эрхийн өдрөөр гарын үсэг цуглуулах захидал бэлдэх, захидал уриалгад гарын үсэг цуглуулах ажилд оролцлоо.

**МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА БА ХЭВЛЭСЭН МАТЕРИАЛ****Олон улсад болж буй хүний эрхийн талаарх шинэ соргог мэдээ**

Олон улсын байгууллагынхаа хувьд Эмнести Интернэшнл байгууллага нь 24 цагийн үйл ажиллагаатай хэвлэл мэдээллийн багийг ажиллуулдаг бөгөөд дэлхий даяар тохиолдож буй хүний эрхийн ноцтой зөрчил, хүний эрхийн салбарт гарч буй ололт амжилтын талаар Эмнести Интернэшнлийн байр суурийг байнга хүргэдэг билээ. Монголын Эмнести Интернэшнл байгууллага ч гэсэн энэ байр сууриа эх хэл дээрээ Монголчуудад зориулан шуурхай хүргэх үүднээс сайн дурын орчуулагч, дадлагын оюутан, кампанит ажлын зохицуулагч нарын тусламжтайгаар 7 хоног бүр 1-2 хэвлэлийн мэдээг орчуулан хэвлэл мэдээллийн байгууллагуудад факс, цахим шуудангаар хүргүүлэв. "Хятад улс цаазаар авах ялыг дахин хянаж үзэхээр болов", АНУ-ын сенатыг Терроризмийн эсрэг дайн"-ны хүрээнд гаргасан хууль тогтоомжоосоо татгалзахыг Эмнести Интернэшнл уриалж байна", "Мексик улс Эрүүгийн шүүхийн Ромийн дүрэмд нэгдсэн 100 дахь улс боллоо", "Индонез улсад сонин эрхлэгчийг хорилоо", "Хүн наймаалахыг хориглох Европын конвенцийг улам сайжруулах хэрэгтэй гэж үзэж", "Олимп Хятадад хүний эрхийн шинэчлэл хийхэд тус дөхөм үзүүлж байна", "Өмнөд Солонгос цагаач ажилчдын эрхийг зөрчиж байна" гэх зэрэг олон арван хэвлэлийн мэдээг илгээсэн байна.

2006 онд зохиосон хэвлэлийн бага хурал

МЭИ нь хэвлэл мэдээллийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн амжилттай ажилласаар ирлээ.

1. 2006 оны 5 дугаар сарын 25-ны 11.00 цагт "Монгол ньюс" хэвлэлийн төвд Эмнести Интернэшнл байгууллагын үүсгэн байгуулагдсаны ой болон жил бүр Эмнести Интернэшнл байгууллагаас эрхлэн гаргадаг 150 гаруй орны хүний эрхийн байдлын талаарх илтгэлийг танилцуулах зорилгоор хэвлэлийн бага хурал хийв. ЭИ-ийн 2005 оны тайланд орсон Монголын хүний эрхийн нөхцөл байдлын талаар УЗ-ийн дарга академич С.Нарангэрэл, дэлхий даяархи улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, "Хүний эхийн төлөө шуугицгаая" кампанит ажлын талаарх мэдээллийг Хөгжмийн зохиолч Г.Пүрэвдорж, сэтгүүлчдийн бүлгийн ахлагч Г.Гангамөрөн нар өгч, сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариулав.

2. 2006 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 11.00 цагт "Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдөр болон Эрүү шүүлтийн тактикийн зураг боловсруулах төслийн талаар Эв Аран ТББ Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран хэвлэлийн бага

хурал хийлгэв. Хэвлэлийн бага хулаар Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрийг улс орнууд хэрхэн тэмдэглэж байгаа талаар Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Тактикийн зураглал боловсруулах төслийн талаар Эв Аран ТББ-ын захирал Н.Мөнхбат, Монгол улсад эрүүдэн шүүх асуудал ямар байгаа талаар Хүний эрхийн үндэсний Комиссын дарга С.Цэрэндорж танилцуулга хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариуллаа

3. 2006 оны 8 дугаар сарын 25-ны 11.00 цагт МҮЭТЭ-ийн Ордны Хэвлэл Мэдээллийн Төвд "Сэтгүүлчдэд туслах зөвлөмж" гарын авлагын танилцуулга хэвлэлийн бага хурлыг зохион байгууллаа. Хэвлэлийн бага хурлаар Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний талаар Академич С.Нарангэрэл, Сэтгүүлчдэд туслах зөвлөмж номын талаар Удирдах зөвлөлийн гишүүн Сэтгүүлчдийн бүлгийн гишүүн, төслийн удирдагч П.Жаргал, Эмнести Интернэшнл байгууллагаас хийж буй ажлууд болон сэтгүүлчдийн эрхийг Эмнести Интернэшнл ямар байдлаар хамгаалдаг талаар Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа нар мэдээлэл өглөө.

4. 2006 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 13.00 цагаас Монголын хэвлэлийн хүрээлэнд "Цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, Монгол улсад хийгдсэн цаазаар авах ялын судалгааны дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийлгэв. "Хүний амьд явах эрх, ба цаазаар авах ял Монголд судалгааны тайлангийн талаар УЗ-ийн дарга академич С.Нарангэрэл, Цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн өдрийг дэлхий дахинд болон Эмнести Интернэшнл байгууллагын хүрээнд хэрхэн тэмдэглэн өнгөрүүлж буй мэдээллийг Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа нар хүргэж сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариулав.

5. 2006 оны 12 дугаар 07-ны өдийн 12.00 цагт Хэвлэлийн Хүрээлэн дээр "олон улсын хүний эрхийг тэмдэглэн өнгөрүүлэх, Олон улсын хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, эрхээ хамгаалж захидал уриалга бичих кампанит ажлын талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулагдлаа. Хэвлэлийн бага хуралд Олон улсын хүний эрхийн өдрийг дэлхийн улс орнууд хэрхэн тэмдэглэн өнгөрүүлдэг болон Монголын Эмнести Интернэшнл байгууллага хэрхэн тэмдэглэж буй талаар Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Захидал уриалга бичих аяны талаар Сэтгүүлчдийн бүлгийн ахлагч Г.Гангамөрөн, Оюутан залуучуудын бүлгийн гишүүн М.Адьяанам нар мэдээлэл өгч сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариуллаа.



**ЗАЛУУЧУУД БА ӨСӨЛТ ХӨГЖИЛ**

МЭИ-ийн ихэнхи сургалтад залуучууд илүү татагдан орж, үүнээс олон нийтэд хандсан ихэнхи кампанит ажилд залуучууд түлхүү орж байсан юм. Залуучуудын оролцоо, санаачлагаар бүтсэн олон нийтэд таниулах болон оюутан залуучуудад хандсан үйл ажиллагаанаас энд толилуулья

33 дугаар сургууль дээрхи клуб

• Нийслэлийн 33 дугаар сургуулийн багш Эрдэнэтуяагийн санаачлагаар 2006 оны 3 дугаар сард 7-10 дугаар ангийн 20 гаруй сурагч гишүүнтэй клуб байгуулагдсан билээ. Клуб байгуулагдсанаас хойш өөрийн сургууль дээрээ хүний эрхийн өдөрлөг зохион байгуулж асуулт хариултын уралдаан, зургийн уралдаан зохион байгуулсан байна. Клубын гишүүд МЭИ-ээс зохион байгуулсан сургалт, кампанит ажилд ч мөн идэвхитэй оролцдог боллоо.

Буддист оюутнуудын холбоон дээрх үйл ажиллагаа

Буддист залуучуудын клубтай хамтран энэ жил бид хоёр дахь удаагаа хүний эрхийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Энэ жил залуучуудын бүлгийн П.Тодрол, З.Балдорж, М.Гэрэлмаа нар Бага оврын зэвсгийн талаархи хэлэлцүүлгийг 2006 оны 9 дүгээр сард хийсэн юм. Бид шашны байгууллагуудтай харилцаа холбоогоо нягтруулсны үндсэн дээр Дэлхийн энх тайвны өдрийг тэмдэглэх үйл ажиллагааг хамтран зохион байгууллаа.

Тольт дунд сургууль дээрх үйл ажиллагаа

• 33 дугаар сургуулийн клубын гишүүд ЭИ-ийн илтгэгч бэлтгэх сургалтанд суусны үр дүнд Тольт дунд сургууль дээр хүний эрхийн нэг өдрийг 2006 оны 5 дугаар сард зохион байгуулав. Өдөрлөгөөр 10-11 дүгээр ангийн 4 ангид ЭИ-ийн талаарх танилцуулгыг хийж хүний эрхийн сургалт зохион байгууллаа. Сургалтын үр дүнд Тольт сургууль ЭИ-ийн клуб байгуулах хүсэлт гаргаад байгаа билээ.

Гурван тамир дунд сургууль

• Гурван тамир дунд сургууль дээр бид хүүхдийн эрхийн өдөрлөгийг тогтмол явуулдаг болсон юм. Өмнө бид “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулж байсан бол энэ жил 20 гаруй сурагчдад хүний эрхийн болон ЭИ-ийн талаархи сургалтыг 2006 оны 4 дүгээр сард зохион байгуулав.

“Оюутны эрх” эрдэм шинжилгээний хурал

• МУИС-ийн Оюутны эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран МУИС-ийн салбар сургуулиудын дунд “Оюутны эрх” эрдэм шинжилгээний хурлыг 2006 оны 5 дугаар сард зохион байгуулав. МУИС-аас бусад сургуулийн гишүүд уг хурлыг зохион байгуулахад оролцсон юм. Хуралд нийт 40 гаруй оюутны илтгэл орсноос ЭЗС-ийн оюутан П.Тодрол нэгдүгээр байр, ХЗС-ийн оюутан О.Мөнхзул хоёрдугаар байр, НУФ-ийн оюутан Цэнгэл нар гуравдугаар байр эзлэв.

Багануурт залуучуудын бүлэг байгуулах аялал

Залуучуудын бүлгийн гишүүд Багануурын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлж, залуучуудыг хүний эрхийн хөдөлгөөнд татан оруулах зорилгоор 2006 оны 5 дугаар сард аялал зохион байгуулсан юм. Багануурын ерөнхий боловсролын сургууль дээр очиж 50 гаруй сурагчдын дунд ЭИ, хүний эрхийн талаархи танилцуулгыг хийхийн зэрэгцээ залуусын харилцааны тухай олон ярилцлагыг хийсэн юм.



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ

Ерөнхий мэдээлэл



1984 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү

шүүлт тулгаж буй явдлыг илрүүлэх, ийм гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг мөрдөн байцааж, ял шийтгэл хүлээлгэхийг оролцогч улсууддаа үүрэг болгосон баримт бичиг болох Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг батлан гаргасан юм. Энэхүү конвенцийн дагуу хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүрэг бүхий Эрүү шүүлтийн эсрэг хороог байгуулсан байна. 1985 онд хүмүүст эрүү шүүлт тулгаж байгаа тухай мэдээлэлд холбогдох улс орнуудын Засгийн газарт эсэргүүцсэн мэдэгдэл илгээх чиг үүрэг бүхий Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай Илтгэгчийг НҮБ томилжээ. Монгол улс 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орж соёрхон баталсан байна. Эмнести Интернэшнл байгууллага нь эрүү шүүлтийн эсрэг кампанит ажлын хүрээнд улс орнуудын Засгийн газрыг Эрүү шүүлтийн эсрэг Конвенцид нэгдэн орж, соёрхон батлахыг нөлөөлөхийг оролдож, ингэснээрээ эрүү шүүлтийг устгах механизмийг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас 2006 онд эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажлын хүрээнд дараах ажлуудыг хийлээ.

“Терроризмын эсрэг дайн нэрийн дор” лекц



АНУ-ын ЭИ-ийн захирал ноён Билл Шульц “Терроризмын эсрэг дайн”-ны тухай лекцийг 4 дүгээр сарын 7-нд МУИС-ийн ХЗС-ийн оюутнуудад уншлаа. АНУ- терроризмтай тэмцэх явцдаа эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилох, нууцаар шорон байгуулан хоригдлуудыг улс орон дамжуулан тээвэрлэж

буй болон эрүүдэн шүүгдэхгүй байх хүний туйлын эрхийн талаар сонирхолтой лекцийг уншсан бөгөөд уг лекцийг Ийгл, TV-9 телевизүүд болон Цагийн хүрд, Ардийн эрх сонины газруудаас сурвалжлан олон нийтэд хүргэлээ.

“Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь” сургалт



Хорих 411-р анги Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийг хорих газраас манай байгууллагад хүсэлт тавьсны дагуу 2006 оны 4 дүгээр сард тус

хорих ангид эрүү шүүлтийн талаар 1 өдрийн сургалт явууллаа. Уг сургалтанд тус хорих ангийн нийгмийн ажилтан, багш, тогооч, нярав хянагч, сувилагч, номын санч зэрэг 20 гаруй хүн оролцов. Сургалтаар эрүү шүүлтийн эсрэг конвенц, хүүхдийн эрхийн конвенц болон бусад олон улсын гэрээ, баримт бичгүүд, насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдтэй хэрхэн харьцах талаарх олон улсын хэм хэмжээнүүдийг танилцуулан, эрүү шүүлттэй тэмцэх аргачлалаар хичээл заалаа. Оролцогчдоос авсан үнэлгээний хуудаснаас харахад сургалтаас хүсч байсан мэдээллээ хангалттай сайн олж авсан бөгөөд цаашид ажилчдад харилцааны чиглэлээр, хүмүүжигч хүүхдүүдэд зориулсан хүүхдийн эрхийн талаарх сургалт зохион байгуулж өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан байна. Мөн энэ сургалтаар олж авсан мэдлэг мэдээллээ цаашид өдөр тутмынхаа ажилд хэрэгжүүлэхээ дурьдсан байна.

• Ном, сонин

Хорих, урьдчилан хорих газруудад эрүүдэн шүүх явдал гаргуулахгүй байхад хөндлөнгийн хяналт шалгалт ихээхэн тустай байдаг. Улс орнууд эрүүдэн шүүхтэй тэмцэх механизмийг бүрдүүлэх үүднээс иргэний нийгмийн байгууллагуудыг хөндлөнгийн хяналт хийхийг нь дэмжиж, зарим орон бүр хуульчилж өгсөн байдаг. Монгол улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэж ороогүй, хяналтын системийг хараат бус хөндлөнгийн болгож чадаагүй байгаа энэ нөхцөлд ТББ-уудад нь хорих цагдан хорих төв дээр хяналт тавьж чадахуйц хэмжээнд мэргэшсэн, тийм чадвартай байх нь туйлын чухал билээ. Тиймээс “Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг” ТББ-уудад зориулсан аргачилсан удирдамж номыг орчуулан, 1000 хувь хэвлүүлэн гаргалаа.

ЭИ-ИЙН БҮТЦИЙН БҮРЭН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2003 оны ЭИ-ийн Олон Улсын Зөвлөлийн Хурал (ОУЗХ)-аас ЭИ-ийн дүрэмд өөрчлөлт оруулж ЭИ-ийн Бүтцийн эрхийг Олон Улсын Гүйцэтгэх Хороо (ОУГХ)-оос олгодог байхаар болгосон юм. Өмнө нь энэ эрхийг ОУНБДНГ-аас олгодог байсан билээ. 2003 онд орсон энэхүү өөрчлөлтийн дагуу Олон Улсын Гүйцэтгэх Хороо олгодог болсноор 2004 оны 12 дугаар сард өмнө нь ОУНБДНГ-аас зөвшөөрөл олгосон бүх бүтцийн статусыг автоматаар баталгаажуулахгүй байхаар шийдвэр гаргасан. Практик амжилтад хүрсэн болоод цаг хугацааны хувьд удаан оршин тогтносон одоо үйл ажиллагаагаа явуулж буй бүх Бүтцийн бүрэн эрхийг баталгаажуулах ажлыг эхлэх бөгөөд Олон Улсын бодлогын хүрээнд ОУГХ-оос баталсан шалгуур үзүүлэлтүүдийг баримтлахаар болсон байна.

2003 оны ОУЗХ-аас Бүтэц бүрт 2007 оны ОУЗХ саналын эрхтэйгээр оролцох дүрмийн өөрчлөлтийг баталж улмаар ОУГХ-оос Бүтцийн бүрэн эрхийг баталгаажуулах ажлыг яаравчлуулах болсон байна. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулж буй Бүтцүүд санал өгөхийн тулд 2007 оны 3 дугаар сараас өмнө энэхүү статусаа баталгаажуулсан байх ёстой гэсэн үг. Шийдвэрийн дагуу Олон улсын хөгжлийн хөтөлбөр (ОУХХ)-өөс Бүтцийг үнэлж, бүрэн эрхийг баталгаажуулах удирдамжийг гаргаж МЭИ-д шалгалтын багийг томилон 2006 оны 6 дугаар сард явуулсан юм. Шалгалтын багт ОУХХ-ээс төлөөлөн хатагтай Элизабет Филд, ОУГХ-оос төлөөлөн Хонконгийн салбарын санхүүч асан Ноён Питер Мок нар байв.

Шалгалтын баг Бүтцийг үнэлж статусыг баталгаажуулах удирдамжийн дагуу манай удирдах зөвлөл, идэвхтэн гишүүд, бүлгийн ахлагч, гишүүд, хамтран ажилладаг байгууллага, бүх ажилтнуудтай нэг бүрчлэн уулзлаа.

Уг удирдамж нь дараах 5 чиглэлээр дүгнэж үздэг.

1. Үүрэг хариуцлагын тухай
2. Гишүүд хамрагчидтайгаа хэрхэн хамтран ажилладаг
3. Идэвхжилт
4. Стратеги төлөвлөгөө, бодлого
5. Өсөлт

Нэгдүгээр үзүүлэлтийн хувьд түншүүд болон гишүүдийнхээ өмнө хүлээх МЭИ-ийн хариуцлага сайн байна. Энэ нь бүх гишүүдийн уулзалт гэх мэт үйл ажиллагаагаар харагдаж байна.

Хоёрдугаар үзүүлэлтийн хувьд бас сайн. Үйл ажиллагаандаа гишүүд хамтрагчдыгаа оролцуулдаг. Шинэ залуу гишүүдийг элсүүлж, янз бүрийн аргуудыг туршиж байна.

Гуравдугаар үзүүлэлтийн хувьд идэвхжилтийн хувьд хангалттай үзүүлэлттэй байна. Идэвхтнүүдийгээ сургадаг, үйл ажиллагаанд оролцуулдаг, бусад байгууллагаас суралцдаг.

Дөрөвдүгээр үзүүлэлтийн хувьд харин төлөвлөгөөгөө одоо байгаагаас илүү удаан хугацаатай гаргавал сайн гэж үзэв.

Тавдугаар үзүүлэлтээр өсөлт бас зорилгодоо хүрч байгаа нь сайн байна. Гишүүдийн бүтээлч чанар нь сайн.

Ерөнхийдөө Монголын Эмнести Интернэшнл бол эрч хүчтэй, дайчин байгууллага юм гэж дүгнэлээ.



ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ



Цаазаар авах ялын тухай асуудал дан ганц эрх зүйн төдийгүй улс төр, философи, социологи, сэтгэл судлал, нийгмийн ухамсарын түвшний асуудал юм. Цаазаар

авах ял гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүчтэй нөлөө үзүүлдэггүй болохыг дэлхий нийтийн туршлага харуулж байна.

Цаазаар авах ялыг халж байгаа улс орнуудын тоо сүүлийн 20 жилд нэмэгдсээр байна. Өнөөдөр дэлхийн 129 орон цаазаар авах ялыг хуулиндаа болон практикт халаад байна. Үүнээс 88 орон цаазаар авах ялыг бүрэн халж, 11 орон дайны гэмт хэргээс бусад тохиолдолд оноохыг хориглож, 30 орон практикт хэрэглэхээ зогсоож сүүлийн 10 гаруй жил ялын гүйцэтгэл хийгээгүй байна. Үлдсэн Хятад, Иран, АНУ зэрэг 68 орон цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа боловч тэдгээрийн зарим нэг оронд ял оноох хэргийн тоог бууруулсан байна.

2006 онд Ази-Номхон далайн орнуудаас Филиппин улс нь хуулиндаа болон практикт цаазаар авах ялыг халсан 25 дахь орон боллоо.

• “Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял Монголд” судалгаа



Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас 2005-2006 онд “Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял Монголд” сэдэвт түүхэн тойм бичих,

тандалтын судалгааг амжилттай хийлээ. АНУ-ын Эмнести Интернэшнл байгууллагын санхүүгийн тусламжтайгаар хэрэгжсэн энэ судалгааг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн багш нар, Монгол улсын дээд шүүхийн судалгааны төв, Монгол улсын цагаатгалын комиссийн судалгааны алба, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагуудтай хамтран явууллаа.

Энэ судалгааны хүрээнд бид цаазаар авах ялыг хэвээр байлгах болон хүчингүй болгохыг хэрэгтэй гэж үзэж байгаа хүн амын хэсгүүдийн харьцааг гаргах, ямар үндэслэлүүдийг гол болгож байгааг хэсэг тус бүрээр тогтоох, ялын бодлого Монгол улсад үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх, түүнийг хэвээр байлгах, эсхүл түүнийг шатчилан халах шаардлагатай эсэхийг судлан тогтоох, цаазаар авах ялын талаарх өөрийн орны түүхэн тоймыг бичихээр зорьсон юм.

Судалгааны багийн удирдагчаар МУИС-ийн ХЗДС-ийн захирал Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Нарангэрэл, төслийн зохицуулагчаар Монгол улсын Гавъяат хуульч, Хурандаа Р.Оюунбадам болон багийн гишүүдээр МЭИ-ийн гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Монгол улсын төрийн албаны ажилтан профессор М. Алтангэрэл, Монгол улсын цагаатгалын комиссын гишүүн, түүхч, доктор Н.Сампилноров, Монгол улсын Дээд шүүхийн судалгааны төвийн захирал шүүгч Д.Дангаасүрэн нар сонгогдон ажиллалаа.

Төслийн 1-р шатанд цаазаар авах ялд хандах хандлагын тандалтын судалгаа /Социологийн судалгаа/-ны хүрээнд МУИС-ийн ХЗДС-ийн эрдэмтэн багш нар иргэд болон хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан хоёр төрлийн тандалтын судалгааны асуулгыг боловсруулсан. МЭИ байгууллагаас судалгааны асуулгыг нийт 5500 ширхэгийг хэвлүүлж, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын оролцоотойгоор Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 4344 иргэд, 558 хуульчдыг оролцуулсан санал асуулгыг явууллаа. Мэргэжлийн хуульчдаас 110 шүүгч, 99 прокурор, 81 мөрдөн байцаагч, 40 өмгөөлөгч, 24 хуулийн зөвлөх, 14 нотариатч, 17 профессор багш нар болон бусад мэргэжилтнүүд судалгаанд хамрагдсан байна.

Эрэгтэйчүүдийн холбооноос оролцосн юм. Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч Ш. Анхмаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи тоо баримт, судалгаа болон ЭИ-ийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын шинэчилсэн стратеги төлөвлөгөөг танилцуулж, Өсөлт хөгжил харицаа хариуцсан зохицуулагч А.Отгончимэг судалгаа хийх арга барилын талаар сургалт зохион байгуулж, Монголд судалгаа хийх ямар салбар байгаа тухай хэлэлцүүлгийг хийсэн юм.

и. Сан арвижуулах сургалт

Сан арвижуулалтын талаарх сургалтыг Сан арвижуулах зохицуулагч Карл Уэтам МЭИ-ийн гишүүдэд зориулсан гарын авлагыг боловсруулж энэ дагуу сургалтыг явууллаа. Эмэгтэйчүүд, Хуульч, Сэтгүүлч, Залуучууд, Багш, Эмч, Чөлөөт бүлгийн 30 гаруй гишүүн оролцов. Гишүүд сан арвижуулах төлөвлөгөө хийх даалгавар аван ажиллаж байна. Сургалтын үр дүнд гишүүд үйл ажиллагаандаа сан арвижуулах үйл ажиллагаа зохион байгуулдаг боллоо.

й. “Эрхийнхээ төлөө шуугицгаая” кампанит ажлаар олон нийтэд сурталчилгаа хийлээ.

Эрхийнхээ төлөө шуугицгаая кампанит ажлын хүрээнд задгай тоглолт зохион байгуулсан билээ. Энэ үеэрээ ажиллах 24 сайн дурын ажилтныг бэлтгэх сургалтыг 5 дугаар сарын 24-нд хийсэн юм. Сайн дурынхан маань ЭИ-ийн талаар ерөнхий мэдээллийг авахаас гадна тухайн кампанит ажил ямар зорилготой, юу хийдэг болох хийгээд тус тусын ажил үүргийн хуваарийн дагуу яаж ажиллах, хүмүүстэй хэрхэн харилцах тухай дадлага хийж бэлтгэв.

к. Дарфурын төлөө үйл ажиллагаанд оролцох тухай сургалт

Суданы Дарфурт НҮБ-ын энхийг сахиулагчдыг оруулахыг уриалсан “Цэнхэр малгайтнууд” үйл ажиллагаа зохион байгуулж буй 15 гишүүнд Дарфурын хүний эрхийн нөхцөл байдал ямар байгаа болон хүмүүстэй хэрхэн харилцах тухай сургалтыг 9 дүгээр сард хийв. Оролцсон гишүүд үйл ажиллагаагаа бүгд амжилттай зохион байгуулав.

л. Яаралтай үйл ажиллагааны дагуу захидал бичих сургалт

Яаралтай үйл ажиллагааны дагуу захидал бичих сургалтыг 5 сард Сайн дурын ажилтан Бедия 3 гишүүнд явуулав. Сургалтаар захидал хэрхэн бичих болон яаралтай үйл ажиллагааны дагуу юуг онцлон анхаарч бичих хэрэгтэйг зааж оролцогч бүрт нэг нэг хэргийн материал өгч захидал бичүүлэв.

м. Бизнес ба хүний эрх сургалт

ЭЗНСЭ-ийн кампанит ажлын бэлтгэл ажлын хүрээнд бизнес ба хүний эрх хэрхэн уялдаж байгаа болон ЭИ бизнесийн байгууллагатай хэрхэн ажиллах ёстой тухай сургалтыг сан арвижуулах зохицуулагч Карл Уэтам 16 идэвхитэн гишүүдэд 8 дугаар сард явуулав. Сургалтын гарын авлагыг орчуулан бэлэн болгосон байна. Энэхүү сургалтыг П.Тодрол хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтаар давтан явууллаа.

н. ЭИ-ийн илтгэгч бэлтгэх сургалт

ЭИ-ийн тухай танилцуулгыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хэрхэн танилцуулах болон илтгэх тухай сургалтын материалыг сан арвижуулах зохицуулагч Карл Уэтам бэлтгэж Залуучуудын бүлгийн ахлагч П.Тодролыг сургагч багшаар бэлтгэсний дагуу ЭИ-ийн 33 дугаар клубын нийт 14 сурагчдад хоёр удаагийн сургалтыг явуулсан байна. Сургалтанд оролцогчид Тольт дунд сургуулийн ахлах ангийнханд давтан явуулахын зэрэгцээ гишүүн өргөжүүлэлт хийж чадсан байна. Мөн залуучуудын бүлгийн бусад гишүүд Багануур дүүргийн Ерөнхий боловсролын сургууль дээр илтгэл ярилцлага хийж 40 гаруй гишүүнтэй клубыг байгуулаад ирлээ. Сургалтуудыг 2006 оны 5 дугаар сард явуулжээ.



сард Хууль зүйн хорооны гишүүдийн тал хувь нь өөрчлөгдсөн бөгөөд тэд энэ хуулийг дэмжих эсэх нь тодорхойгүй байсан. МЭИ-ийн гишүүд дэмжигчдээс амьд явах эрхийг баталгаажуулах түүхэн алхам хийж байгаа Үндэсний Ассамблейн Хууль зүйн хорооны гишүүд, тус улсын Ерөнхийлөгч болон Хууль зүйн сайдад хандан цаазаар авах ялыг халснаараа Өмнөд Солонгос улс нь Азийн бүсийн орнууд дотроо хүний эрхийг хүндэтгэн сахиулагч үлгэр жишээ орон болох төдийгүй дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн чухал алхам болно гэдгийг дурдаж, цаазаар авах ялыг бүрэн халахыг уриалсан өргөх бичиг илгээсэн юм. Өмнөд Солонгосын Хууль зүйн яамнаас 2006 оны 11 дүгээр сарын 9-нд бичсэн хариу захидалдаа хууль зүйн яам цаазаар авах ялын талаар судалж байгаа бөгөөд уг хуулийн төсөл нь Үндэсний Ассамблейгээр хэлэлцэгдэх үеэр бидний барьсан өргөх бичгийг авч хэлэлцэн уг хуулийн төслийг дэмжинэ гэдгээ өгүүлсэн байна.

“Үхдэл явж байна” кино хэлэлцүүлэг



Монгол дахь цаазаар авах ялын талаар хийсэн судалгаагаар иргэдээс илүүтэй хуулийн байгууллагын ажилтнууд энэ ялыг дэмжиж

байгааг олж тогтоосон юм. 12 дугаар сарын 2-нд Эмнести Интернэшнлийн УЗ-ийн гишүүд Ц.Оюунбаатар, Б.Энхтуяа, хуульчдын бүлгийн гишүүд Ц.Цэмбэлмаа, Ч.Аюурзана нар удирдан зохион байгуулсан олон нийтийн үзэл бодолд нөлөөлөх, цаазаар авах ял оноосноор гэмт хэрэг буурахад нөлөөлсөн тухай ямар ч нотолгоо байхгүй бөгөөд амьд явах эрхийг зөрчиж байгаа хүнлэг бус шийтгэл мөн гэдгийг таниулах зорилгоор “Үхдэл явж байна” киногоор хэлэлцүүлэг явууллаа. Уг хэлэлцүүлэг өмгөөлөгч, шүүгч, прокурорууд оролцсоноороо онцлог болов. Нийтдээ 40 орчим хүн оролцож Монгол улсын эрүүгийн хуулинд байгаа цаазаар авах ялын талаарх өөрсдийн байр суурь, дэлхий нийтийн чиг хандлага болон цаазаар авах ялын талаарх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийллээ. Хэлэлцүүлгийн төгсгөлд авсан санал асуулгын дүнгээс харахад оролцогчдын 69 хувь нь цаазаар авах ялыг халах нь зүйтэй гэж үзсэн байна. Үлдсэн хэсэг нь Монголын өнөөгийн нийгэмд энэ ялыг халах нөхцөл байдал бүрдээгүй тул одоохондоо эрүүгийн хуулинд энэ заалтыг байлгах хэрэгтэй гэсэн байр сууринаас хандаж байв.

<p>Олон улсын кампанит ажлын зохицуулагчдын хурал</p>	<p>2006 оны 10-р сарын 19-22 (Лондон хот)</p>	<p>Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын талаарх шинэчилсэн стратеги төлөвлөгөөний ирэх 4 жилд хэрэгжүүлэх зорилго, зорилт, хамрах хүрээний талаар дэлгэрэнгүй ярилцаж, кампанит ажлын хүрээнд гарч байсан ололт амжилт, хүндрэл бэрхшээлүүдийн талаарх санал бодлоо солилцон дүн шинжилгээ хийв. Мөн ЭИ-ээс 2008 оноос дэлхий даяар явуулж эхлэх “Нэр төр” кампанит ажлын хүрээнд Ядуурлын эсрэг хүний эрхийг хамгаалах кампанит ажлын бодит боломж бололцоог тодорхойлох, хэрхэн яаж хамгийн дээд үр дүн, амжилтанд хүрч болох, мөн Эмнести = Идэвхжилтийн хүрээнд гишүүд дэмжигчдээ идэвхжүүлэхэд юуг анхаарах талаар ярилцлаа. Тус хурлын үер Азийн бүсийн кампанит ажлын зохицуулагч нар уулзаж, хоорондын харилцаа холбоогоо сайжруулахад юу дутагдаж байгаа талаар санал солилцлоо.</p>	<p>Г.Амарзаяа, Кампанит ажлын зохицуулагч</p>
--	---	---	---

ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ ШУУГИЦГААЯ



2001 оны 9 дүгээр сарын 11-ний Нью-Йорк хотод болсон эмгэнэлт явдлаас үүдэлтэй юм. Ёоко Оно хүний эрх нь маш чухал гэдгийг олон түмэнд ойлгуулах үүднээс Эмнести Интернэшнл байгууллагад "Imagine" дууны эрхийг өгсөн бөгөөд 2002 онд Америкийн Эмнести Интернэшнл байгууллага хүмүүст эрхээ хамгаалах ухамсарыг бий болгох зорилгоор "Imagine" кампанит ажлыг өрнүүлсэн юм. Кампанит ажил үр дүнгээ өгч байгаа харсан Оно түүний нөхөр Ленноны дууны бүтэн цомгийг дахин хандивласан юм.

Эмнести Интернэшнл байгууллагын Олон Улсын Нарийн Бичгийн Дарга Нарын Газар, Art for Amnesty (ЭИ байгууллагын хүний эрхийн үйл ажиллагааг дэмжихийн тулд нэгдсэн олон орны урлагийнхны баг), Америкийн Эмнести Интернэшнл байгууллагууд хамтран хүний эрхийн салбарт шинэ эрин бий болгох зорилгоор Ленноны дуунуудаас түүвэрлэн дэлхий нийтийг хамарсан шинэ соргог "Эрхийнхээ төлөө шуугицгаая" кампанит ажил өрнүүлээд байна.

Эрхийнхээ төлөө шуугицгаая хөдөлгөөн нь Эмнести Интернэшнл байгууллагаас зохион байгуулж буй хүний эрхийг дэмжигч шинэ залуу гишүүдийг татах хөгжмийн цогц, баяр ёслол юм. "Imagine" зэрэг Жонн Ленноны дуунуудыг алдартай дуучид, жүжигчид ЭИ-д зориулан дахин бичүүлж байна.

Дэлхий нийтээр хүний эрхийг хүндэтгэн сахих хүсэл зорилготой шинэ үеийг бий болгохын төлөө бүхий л боломжоороо шуугиан дэгдээхийг уриалах юм. Бид үг хэлснийхээ төлөө хоригдож буй, хүний эрхийн төлөө тэмцсэнээсээ болж гадуурхагдаж буй хүмүүсийн төлөө шуугиан дэгдээх болно. Одоогоор Black Eyed Peas, The Postal Service, Snow Patrol, Maroon 5 зэрэг хамтлаг дуучдын бичлэгийг гаргасан бөгөөд 2006 онд Аврил Лавин болон бусад борлуулалтаараа тэргүүлэгч дуучдын шинэ бичлэгийг нэмж гаргах болно. Одоо хүмүүс бидний дууг сонсож, сар бүр гаргадаг интернэт сэтгүүлд гарын үсэг зурцгааж, гаргасан цомгийг худалдан авч, эсвэл Эрхийнхээ төлөө шуугицгаая аяыг утсан дээрээ тохируулах гэх мэтээр Эмнести Интернэшнл болон хүний эрхийг дэмжиж байна. Дуу хөгжим эрх чөлөө хувьсал эв санааны нэгдлийн хэлээр ярьдаг.

2006 оны "Эрхийнхээ төлөө шуугицгаая" кампанит ажил

Эрхийнхээ төлөө шуугицгаая кампанит ажлын гол онцлог нь нэр нь түгсэн, хүмүүнлэгийн үйлсэд идэвхитэй дуучдыг оролцуулж байгаад оршино. Иймээс Эмнести Интернэшнл хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, хүний эрхийн төлөө уриаг олонд хүргэхээр нэртэй дуучид хамтлаг, урлагийн хүмүүсийг урин оролцуулсан юм. Бид дуучидтай биечлэн уулзаж сонгосон бөгөөд Эмнести Интернэшнлийн хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх шалгуурыг тавьсан бөгөөд эдгээр дуучдын бүтээлийг нийтэд түгээж, шинэ залуу үеийг хүний эрхийн төлөө үйлсэд татан оролцуулахад чиглүүлэхээр зорьсон билээ. Энэ ажиллагааг Монгол улсаас хамгийн анх Хөгжмийн зохиолч Г.Пүрэвдорж дэмжиж, урлагийн хүмүүст энэ талаарх мэдээллийг хүргэснээр Нисванис хамтлагийнхан, дуучин Буянаа, дуучин Номинжин, Булсара хамтлаг, Номадс хамтлаг, хөөмийч Д.Баярсайхан, Г.Адъяадорж нар дэмжиж хамтран оролцохоо илэрхийлсэн юм.



Хүн яг цагаа тулахаараа нэг их урт у д а а н насалдаггүй. Тэгэхдээ хүн амьд явахдаа хүн шиг амьдрахыг эрмэлздэг. Ингэхийн тулд хүн өөрийн эдлэх ёстой эрх, үндсэн эрх чөлөөгөө эдлэх зайлшгүй шаардлагатай болдог. Хүний эрх бол төр засгаас өгсөн өглөг буян бишээ. Энэ бол жам ёсны хүний өөрийн нь хүн шиг амьдрах нэн чухал хэрэгцээ байдаг. Хэрвээ хүмүүс өөрсдийнхөө төлөө ганц нэгээрээ тэмцвэл заримдаа ялагдаж, түүнийхээ төлөө золиослогддог. Тийм учраас бүгдээрээ хамтдаа эрхийнхээ төлөө тэмцэцгээе. Бүгдээрээ дуу хоолойгоо нэгтгэн эрхийнхээ төлөө шуугицгаая.

2006 оны 5 дугаар сарын 27-ны нартай сайхан өдөр Эрх чөлөөний талбайд Монголын Эмнести Интернэшнлийн Удирдах зөвлөлийн дарга, академич С.Нарангэрэл дээрх уриалгыг хүмүүсийн сэтгэлд хоногшин үлдтэл гал цогтойгоор хэлснээр Эмнести Интернэшнлийн энэ өдрийн ажиллагаа эхлэв.

Нисванис хамтлагийнхан хүний эрх зөрчигдөж буйд санаа зовж байгаагаа илэрхийлэн залуучуудыг эрхээ хамгаалж сурахыг уриалан ая дуугаа өргөлөө. Мөн Булсара, Номадс зэрэг хамтлагууд Хүний эрхийн

<p>Онцгой байдлын сургалт (НҮБДДКГ-аас хүмүүнлэгийн байгууллагын ажилтнуудад зориулан болзошгүй аюул заналхийлэлд анализ хийн энэ байдлаас урьдчилан сэргийлэх, хамтран ажиллагсадаа болон өөрийгөө хамгаалахад бэлтгэх зорилгоор зохиодог)</p>	<p>2006 оны 6 дугаар сарын 19-23 Тайланд Пранбури хот</p>	<p>Хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг байгууллагуудын ажилтнууд өөрийн албан тасалгаа, амьдардаг орчин тойрныхоо аюулгүй байдалд хэрхэн анхаарал тавих болон тухайн ажиллаж байгаа орон нутгийн хүмүүст нөлөөлж, хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх мөн хүмүүнлэгийн тусламж үзүүлэх явцад дүрвэгсдийн лагерьт гарах бэрхшээлүүдийн үед асуудлыг аль болох тайван замаар шийдэх, зэвсэгт мөргөлдөөн, барьцаалагдсан үед хэрхэн яаж ажиллах талаарх арга барил, чадвар эзэмших 5 өдрийн сургалт боллоо.</p>	<p>Г.Амарзаяа, Кампанит ажлын зохицуулагч</p>
<p>Цаазаар авах ялын талаарх шинжээч, мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалт</p>	<p>2006 оны 7 дугаар сарын 07-09</p>	<p>Ази номхон далайн бүсийн нийт 27 шинжээч, судлаач, хуульчид оролцсон уг зөвлөлдөх уулзалтаар Цаазаар авах ялыг эсэргүүцэх Азийн Сүлжээ (ADPAN)-г байгуулах, интернэт дээр блок үүсгэх, цаазаар авах ялыг халсан Филиппин улсын туршлагыг судлах, Солонгос улс парламентаараа цаазаар авах ялыг халах хуулийн төсөл хэлэцэж байгаад дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлаар ярилцаж тодорхой шийдвэрүүдэд хүрсэн бөгөөд Цаазаар авах ялын өнөөгийн нөхцөл тус бүс нутагт ямар байгаа талаар зураглал гаргаж, хууль эрх зүйн</p>	<p>Б.Алтантуяа Гүйцэтгэх захирал</p>



Михайл Трепакшиныг баривчлан хорьж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үзүүлэхгүй байгаад анхаарлаа хандуулж эмнэлгийн тусламж үзүүлэх, хэргийг нь шударга шүүхээр шийдвэрлэхийг, мөн 1989 онд ардчиллыг дэмжих хөдөлгөөнд оролцож байсныхаа төлөө гадаадын дайсны байгууллагад хууль бусаар мэдээлэл дамжуулсан хэргээр Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүн багш Жан Шангуанд 10 жил хорих ял оноож Хунань дахь шоронд хорьсны улмаас сүрьеэ өвчтэй болсон боловч өнөөг хүртэл шаардлагатай эмчилгээ үзүүлэхгүй байгаа, тэрчлэн гэр бүлийнхэнтэйгээ уулзах эрхийг нь хааж жилд ганц удаа ердөө 10-хан минутаар уулзуулж буйг буруушаан Хятадын эрх баригч нарыг Хоригдлуудтай харьцах наад захын жишиг хэмжээг дагаж мөрдөхийг уриалсан захидалд нийтдээ 144 гарын үсэг цуглуулан илгээв.



ОЛОН УЛСЫН ХУРАЛ, СЕМИНАР

Хурал, зөвлөгөөн, сургалт, семинарын нэр	Хаана, хэзээ болсон	Гол асуудлууд	Оролцогчийн нэр
Сайн дурын үйл ажиллагааны талаарх аялан сургалт	2006 он 3 дугаар сарын 07-22 Энэтхэг	Энэтхэгт сайн дурын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг судалж, сайн дурын үйл ажиллагааны удирдлагын тогтолцооны талаарх сургалтад хамрагдав. Энэ үеэр Энэтхэгийн хот суурин болон зах хязгаар мужид орших 10 байгууллагын үйл ажиллагаатай танилцжээ	А.Отгончимэг Өсөлт хөгжил хариуцсан зохицуулагч
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын стратегийн талаарх Эмнести Интернэшнл байгууллагын кампанит ажлын зохицуулагчдын уулзалт	2006 оны 2 дугаар сарын 23-25 Хонконг	Кампанит ажлуудыг хэрхэн зохион явуулах талаарх сургалтанд хамрагдаж, шашин болон ёс заншлын хоцрогдсон үзлийн талаар санал солилцов. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, эрчүүдийг уг ажиллагаанд татан оролцуулах, хүн худалдаалах, хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хамгаалах, талаар цаашид ажиллах ажлын чиг хандлагыг тодорхойлсон.	Б.Энхтуяа УЗ-ийн гишүүн, хуульчдын бүлгийн ахлагч
Хүний эрхийн кино фестиваль ба кино фестиваль зохион байгуулах сургалт	2006 оны 3 дугаар сарын 8-12-нд Нидерланд улсын Амстердам хот	Энэ нь хүний эрхийн зөрчлийн талаар кинонд хэрхэн илэрхийлсэн ба хүний эрхийг хөндсөн сэдэвт кино аль хэр хийгдэж байгаа талаар бусад орны төлөөлөгчидтэй харилцан санал бодлоо солилцож түүний зэрэгцээ хэлэлцүүлгүүдийг явуулсан.	Ш.Отгонбаяр Сэтгүүлчдийн бүлгийн гишүүн
Зэвсэглэлийг хянах кампанит ажлын хүрээнд зохиогдсон хурал	Филиппин 2006 оны 3 дугаар сарын 29-31	Зэвсэглэлийг хянах кампанит ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, бусад орны төлөөлөгчидтэй харилцан санал солилцов. Сая сая дүр төрх кампанит ажлын талаар тайлагнаж, засгийн газарт гардуулж өгөх асуудлаар төлөвлөгөө гаргаж, Ази номхон далайн бүсийн засгийн газруудад хандан хамтарсан мэдэгдэл хийв	Э.Отгончулуун Кампанит ажлын зохицуулагч



илгээсэн бөгөөд иргэдийн хүний эрхийн талаархи ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор танилцуулга сурталчилгааны ажлуудыг хийлээ.

ЗЭВСГИЙГ ХЯНАЯ

Эрхэм хүндэт Парламентын Гишүүд ээ,

Олон улсын хэмжээнд галт зэвсгийг хараа хяналтгүйгээр худалдаалах, тээвэрлэх нь хүний эрхийн зөрчлийг хурцатгаж байгаа бөгөөд энэ нь хүний үнэ цэнийг алдагдуулж байгаа сунжирсан дайны гол хэрэгсэл болж байна. Жил бүр олон зуун мянган хүн галт зэвсгийн улмаас амь насаа алдан, орон гэрээсээ дайжин, эрүү шүүлтэд өртөн тарчилж, эрэмдэг зэрэмдэг болж байна. Олон улсын хэмжээнд Непал, Колумб, Чечень болон бусад дотооддоо мөргөлдөөнтэй улс орнуудад галт зэвсэг нийлүүлэх явдал үргэлжилсээр байна.

Галт зэвсгийг экспортолдог, импортолдог, дамжин өнгөрүүлдэг, үйлдвэрлэдэг бүх л улс орны засгийн газрууд олон улсын хэмжээнд бүх төрлийн галт зэвсгийн худалдаа, тээвэрлэлтийг байнга хянах үүрэгтэй. Улс орнууд нь иргэдийнхээ амь нас, эрх чөлөө, халдашгүй дархан байдлыг гадаадын зэвсэгт хүчний дайралтаас болон дотоод дахь хууль сахиулах байгууллагын ажилтны зүй бус ажиллагаанаас хамгаалах, мөн улс орныхоо аюулгүй байдлыг хангах үүднээс хуулийн хүрээнд зэр зэвсэг эзэмших эрхтэй. Үүний зэрэгцээ нийлүүлэгдсэн галт зэвсгийг олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйг зөрчих хэрэгсэл болгохгүй байх хууль ёсны хариуцлагыг хүлээдэг билээ.

Дэлхийн өнцөг булан бүр дэх парламентын гишүүдийг Олон Улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага, Бага оврын галт зэвсгийн эсрэг олон улсын үйл ажиллагааны сүлжээ, Ядуурал, шударга бус байдалтай тэмцэх Оксфам Интернэшнл байгууллагуудын хамтарсан зэвсгийг хянах дэлхий нийтийн кампанит ажил болон Бага оврын галт зэвсгийн асуудлаархи Парламентийн чуулга уулзалтаас уг кампанит ажлыг дэмжихийг уриалж байна.

2006 онд болох НҮБ-ын Бага оврын галт зэвсгийн хэрэглээг хянах үйл ажиллагааны хөтөлбөрийг дүгнэх бага хурлаар бид энэ асуудалд ахиц дэвшил гаргах боломжтой юм. Галт зэвсгийн тээвэрлэлтэнд хатуу хяналт тавихад өөрийн орны засгийн газраа шаардан оролцуулахыг бид парламентын гишүүдэд уриалж байна.

Энэ тогтоолын 3-7 дугаар зүйлд: Галт зэвсгийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, галт зэвсгийн тээвэрлэлтэнд засгийн газрууд хатуу хяналт тавихыг; 3-р зүйлд: улс орнууд нь Галт зэвсэг тээвэрлэх тухай дэлхий нийтийн зарчмыг хүлээн зөвшөөрч дагаж мөрдөхийг; 4-р зүйлд: Галт зэвсгийг худалдаалах тухай гэрээнд олон улсын шинэ зөвшилцөлийг тусган хэрэгжүүлэхийг тус тус шаардсан байна.

Галт зэвсэг худалдаалах нь чухал асуудал бөгөөд энэхүү үйл ажиллагааг эрчимтэй явуулахад юуны өмнө НҮБ-ын хурлын зарчмуудын дагуу хэлэлцэн тохирох бодит боломж байгаа гэдэгт бид итгэлтэй байна. Галт зэвсгийг үндэсний болон олон улсын хэмжээнд үр бүтээлтэй хатуу хяналтанд байлгаж, асуудлуудыг иж бүрэн өргөн хүрээтэй хэлэлцэхэд хамруулах нь мэдээжийн хэрэг. Энэ бүхэн нь хурлын тогтоолд заагдсан бөгөөд дор дурдсан зүйлүүдийг багтаасан болно. Үүнд:

- Галт зэвсэг болон хамгаалалтын хэрэгсэл зэвсгийг бүртгэх, хэрэглээнд нь хяналт тавих;
- Галт зэвсгийн зуучлалд хяналт тавих, /2 дугаар зүйл/; Зэвсэгт хүчин, эрүүгийн шүүхийн систем болон хууль сахиулах байгууллагууд зэрэг улсын бүх л аюулгүйн албаныхан галт зэвсгийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, /8-9 дүгээр зүйл/;
- Иргэдийн галт зэвсгийн эзэмшилд хяналт тавих /10 дугаар зүйл/ гэх мэт.



БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Бүх гишүүдийн уулзалт

Бүх гишүүдийн уулзалт нь МЭИ-ийн үйл ажиллагааны төлөвлөлтийг нарийвчилан танилцуулах, зохиогдсон үйл ажиллагааг тогтмол тайлагнах, гишүүдийн санал хүсэлтийг сонсох, үйл ажиллагаанд гишүүдийг өргөнөөр татан оролцуулахын зэрэгцээ хүний эрхийн сургалт, тэмцээн, илтгэл, хэлэлцүүлэг явуулах зэргээр МЭИ байгууллагын дотоод ардчилалыг бэхжүүлэх, гишүүдийг идэвхижүүлэхэд оршино. Бүх гишүүдийн уулзалт улиралд нэг удаа зохион байгуулагддаг. 2006 оны хувьд уулзалт бүр өөр өөрийн онцлогтой зохион байгуулагдаж байлаа.

2006 оны бүх гишүүдийн анхдугаар уулзалт буюу Хаврын өдөрлөг



4 дүгээр сард зохиогдсон анхдугаар уулзалтыг ЭЗНСЭ-ийн кампанит ажилд бэлтгэж эхэлцгээе уриан дор явуулав. Уулзалтанд 50 гаруй гишүүд оролцжээ. Уулзалтаар 1-3 дугаар сард бид ямар ажил хийсэн тухайгаа тайлагнаж ирэх улиралд хийгдэх ажлыг танилцуулаад оролцох саналыг нээлттэй хүлээн авлаа. Гишүүдэд ЭЗНСЭ-ийн талаар ерөнхий ойлголт өгөх сургалтыг ЭЗНСЭ-ийн кампанит ажлын зохицуулагч, санхүүгийн ажилтан Т.Баярмаа явуулсан бөгөөд гишүүдэд ЭЗНСЭ-ийн талаархи материал түгээж, усны тухай сурталчилгааг үзүүлсэн юм. Уулзалтаар сан арвижуулах ажлаа ч бас орхигдуулсангүй. ЭИ-ийн кампанит ажлын футболка, тэмдэг, лаа зэргийг дуудлага худалдаагаар борлуулж 54800 төгрөгийн сан арвижуулав. Сайн дурын ажилтан Бедия Акюз АНУ болон Хятадын эрх баригч нарт тус улсын иргэдийн цаазаар авах ялыг цуцлах болон өмгөөлүүлэх эрхийг хангах талаар захидал уриалгад гарын үсэг цуглуулав. Захидал бүрт 40 гаруй хүний гарын үсэг зурав.

Хоёрдугаар уулзалт буюу Өртөөчилсөн аян

Хоёрдугаар уулзалтыг 6 дугаар сард зохион байгуулав. ЭИ-ийн зорилго зорилт, төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт санхүүжилт, кампанит ажил, түгээмэл үг хэллэг, өөрийн орон дахь үйл ажиллагаа, хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн тухай мэдээллийг маш богино хугацаанд таниулах зорилгоор өртөөчилсөн аяныг явууллаа. Уулзалтанд 40 гаруй гишүүд, идэвхитнүүд оролцлоо.

• “Одон орны өртөө” нь Нар, сар, алтан гадас, 7 бурхан одыг дуран авайгаар харж бид ямар хэтийн зорилго, эрхэм зорилгод юуг үнэт зүйлсээ болгон баримталж Уялдаат стратеги төлөвлөгөөгөө хэрхэн хэрэгжүүлэх тухай ярилцдаг. Өртөөг өсөлт хөгжил харилцаа хариуцсан зохицуулагч А.Отгончимэг хөтлөн явуулав.

• “Фото галерей нь” ЭЭХТЗКА, Зэвсэглэлийг хянах, Эрүү шүүлтийг зогсоох, Цаазаар авах ялыг халах, ОУЭШ, Улс орнууд дахь хүний эрхийн ажил хэрхэн явагдаж байгааг зурагт самбараас үзүүлжээ. Галерейг Кампанит ажлын зохицуулагч Э.Отгончулуун тайлбарлав.

• “Боловсрол өртөө” нь мөн зурагт самбараар Хууль хэрэгжүүлэх ажилтнуудад зориулсан сургалт, Ялтнуудад зориулсан сургалт, Гишүүд, дэмжигчдэд зориулсан сургалт, Цаазаар авах ялын талаархи кампанит ажил, Хүний эрхийг хамгаалагчдын төлөө ажил, иргэдэд өгөх хууль зүйн зөвлөгөөг хэрхэн өгч байгааг Хуульчдын бүлгийн ахлагч Б.Энхтуяа танилцуулав.

• “Цайны өртөөг чөлөөт бүлгийн ахлагч, сэтгэл зүйч Д.Оюунномин хариуцан ажиллуулж хамгийн шилдэг онигоо ярьсан хүнийг шалгаруулав. Энэ өртөөнд гишүүд бие биетэйгээ илүү дотно танилцах боломж олдсон гэдэг.

• “Сангийн өртөө”-г Санхүүгийн ажилтан Т.Баярмаа явуулж МЭИ-ийн Санхүүгийн эх үүсвэр хаанаас орж, яаж зарцуулагдаж байгааг диаграмаар харуулж тайлбарлав.

• “Сүлжээ өртөө”-нд ОУНБДНГ-ын болон МЭИ-ийн бүтэц ямар загвартай болохыг схемээс үзэж салбар, орон тоо бүрт хэн байдаг хийгээд, мэдээлэл хэрхэн түгээдэг хийгээд хүлээн авдаг тухай Сэтгүүлдчийн бүлгийн ахлагч Г. Гангамөрөн танилцууллаа.



Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлт гаргахгүй байхад цагдаагийн байгууллагын ажилтнууд өндөр хэмжээнд мэргэшсэн, галт зэвсэг тусгай хэрэгсэлийг хуулийн дагуу хэрэглэх, хэрэглэх явцдаа үйл ажиллагааны алдаа гаргахгүй байх явдал хамгаас чухал байдаг. Иргэдийн дунд явуулсан санал асуулга, хэлэлцүүлгээс харахад цагдаагийн байгууллагын ажилтнуудын хүч хэтрүүлэн хэрэглэсэн, галт зэвсэг тусгай хэрэгсэлтэй буруу харьцсан явдлын талаар гомдоллох нь цөөнгүй байдаг.



Төслийн хүрээнд Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас “Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь” цагдаагийн үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулан

гаргаж 1000 хувийг хэвлэв. Мөн түүнчлэн Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулан гаргаж 50 хувийг хэвлэн гаргав. Үүний дараагаар Эмнести Интернэшнл байгууллага 24 сургагч багшийг бүтэн 2 өдрийн сургалтанд хамруулж дадлага ажил хийлгэн бэлтгэсэн бөгөөд багш нар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дархан, Эрдэнэт, Төв аймаг, Хан-Уул дүүрэг, 801, 805-р ангийн цагдаагийн хэлтсүүд дээр очиж нийт 60 хүн оролцсон сургалтыг зохион байгуулж, 10-14 хоногийн дараа дахин очиж, нэмэлт сургалт болон хэлэлцүүлгүүдийг өмнөх сургалтанд оролцсон 51 цагдаагийн алба хаагчдын дунд зохион байгуулав.

Төсөл өөрийн тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн бөгөөд цагдаагийн алба хаагчдаас өндөр үнэлгээ авснаас гадна Дархан, Хан-Уул дүүрэг, Сонгино хайрхан дүүргийн цагдаагийн газраас номыг олон хувиар хэвлэж бусад цагдаагийн ажилтнуудад тараах, сургалтыг бусад анги салбаруудад явуулах, сургалтандаа олон хүн хамруулахыг хүссэн албан захидлууд хүлээн авсан нь сургалтыг хөндлөнгийн байгууллагууд ч өндөр үнэлж байгааг харуулсан хэрэг боллоо.

Төслийн 1-р үе шатанд гарын авлага боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар холбогдох байгууллагуудад хандаж 5 удаагийн уулзалт хийн докторант Б.Алтанбагана, цагдаагийн тусгай тасгийн алба хаагч Т.Гантулга, Цагдаагийн академийн захирал доктор М.Батаев, Эмнести Интернэшнлийн сургагч, багш сэтгэл судлалын ухааны докторант Д.Оюунномин нар оролцов.

2-р үе шатанд Гарын авлагын эхний төсөлд үндэсний хууль эрх зүйн зүгээс Б.Энхтуяа, Ч.Аюурзана, олон улсын эрх зүй болон цагдаагийн ажиллагааны талаас

нь Б.Алтантуяа, М.Батаев нар тус тус шүүмж бичив. Шүүмжийн дагуу дахин боловсруулалт хийж шүүмжлэгч нарт дахин танилцуулав.

3-р үе шат

Н о м ы г ч а н а р т а й сайн хийх үүднээс 2 удаагийн шүүмж, боловсруулалт орсон, номын эх бэлтгэлд орох зургийн чанарыг сайжруулах үүднээс эрэл хайгуул хийхэд хугацаа ихээхэн хугацаа зарцуулсан бөгөөд багшийн гарын авлагыг энэ үе шатанд боловсруулж шүүмжийг заах арга зүй, агуулга дээр голчлон анхаарч Б.Алтантуяа, Д.Оюунномин, М.Батаев нар хийв.



4-р үе шат Үйл ажиллагааны гарын авлагыг 1000 хувь, багшийн гарын авлагыг 50 хувийг хэвлүүлэв. 8 дугаар сарын 19-нд сургагч багшийн анхны сургалтыг явуулсан бөгөөд хуульч өмгөөлөгчдөөс 8, хүний эрхийн сургагч багш 8, цагдаагийн 8 алба хаагчийг бэлтгэв. Сургалтаас цагдаагийн алба хаагч нарт нэмэлт мэдлэг ур чадвар, хуульч, хүний эрхийн сургагч багш нарт цагдаагийн үйл ажиллагааны талаарх нарийвчилсан мэдлэг шаардлагатай байгааг харгалзан 1 багш 1 хуульч, 1 цагдаа оролцсон 3 хүнтэй багуудад хуваан дадлага олгох ажил, сургалтын туршилтыг явуулав. Үүний дараагаар 2 дахь шатны сургалтыг явуулж багуудыг сонгож авсан цагдаагийн хэлтэс дээр сургалт зохион байгуулав.

Сургагч багш нар 10-15 хоногийн хугацаатайгаар 2 дахь шатны сургалтыг эхний оролцсон 10 хүндээ дахин явуулж 10 дугаар сарын 20 гэхэд төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгав.

Төслийг амжилттай болгосон зүйл нь цагдаагийн үйл ажиллагааны гарын авлага нь энгийн ойлгомжтой аргаар бичигдэж, цагдаа нарт эн тэргүүний шаардлагатай байгаа асуудлыг хөндөж чадсан, хоёрт сургалт нь хүнтэйгээ тулж ажилласан бөгөөд номыг уншиж хэрэгжүүлж туршиж үзэх хугацаа олгосон болон номын гарын авлагыг боловсруулах хэсэгт Цагдаагийн академийн захирал өөрийн биеэр оролцож зөвлөмж өгсөнд оршино. Нөгөөтэйгүүр сургалтын ач холбогдлыг цагдаагийн байгууллагууд өндрөөр үнэлж, цаашид сургалтыг цагдаагийн алба хаагчдад явуулах зорилгоор бага дунд тушаалын алба хаагчдаа оролцуулж, өөрсдийн санаачилгаар 2 дахь сургалт явагдахын өмнө цагдаагийн хэлтэс дээрээ алба хаагчдаа сургалтыг явуулж номын хэрэглээг туршиж үзэн санал бодлоо хуваалцаж байсан нь манай ажлын үр дүн 60 хүнийг сургалтанд хамруулснаар зогсоогүй илүү өргөн хүрээг хамарч чадав. Энэ төслийг хэрэгжүүлэх явцдаа Монголын Эмнести Интернэшнл нь Цагдаагийн академи, Цагдаагийн Ерөнхий газар болон сонгогдсон цагдаагийн 6 хэлтэстэй хамтран ажиллаж, түншлэлийн харилцаагаа өргөжүүлж чадсан болно.

Сургалтуудыг оролцооны аргаар зохион байгуулсан бөгөөд дунд сургуулийн хичээлүүдээр хүний эрхийг заах нь сэдвээр булангийн аргаар ажилласны эцэст багш бүр хүний эрхийн тухай ойлголтыг өөр өөрсдийн хичээлээр хэрхэн нэгтгэж зааж болох талаар бүлгээр ажиллаж, олон сайхан санаа дэвшүүлж, нэгж хичээлийн төлөвлөгөө гаргасан нь сургалтын нэг чухал үр дүн болсон юм.

Түүх бол хүний эрхийн хөгжил хувьслыг заах үндэс тулгуур бөгөөд үе үеийнхний хүний эрхийн төлөө хөдөлгөөн, тунхаглалын зарчим хэм хэмжээ, конвенц протоколуудыг түүхийн хичээлээр заах бүрэн боломжтойг түүхийн багш нар болон арга зүйчид бүлгээр ажиллаж харууллаа.

Бүх үеийнхний хүний эрхийн тухай асуудлууд үндэсний болоод гадаадын уран зохиолд тусгагдсан байдаг ба өөрийн үндэсний уран зохиол нь хүний эрхийн зөрчлийг ойлгох, тэдгээрийн талаар санал сэтгэгдлээ солиход хамгийн хялбар арга зам байдгийг хэл, уран зохиолын багш нарын баг “Хоньчин Найдан”, “Гологдсон хүүхэн”, “Цагаан сар ба хар нулимс” “Шүхэрч Буниа”, “Манай ангийнхан” зэрэг өгүүллүүдээр гаргаж үзүүлж байлаа. Хүний эрхийн асуудлыг математикийн хичээлтэй хамааруулан ойлгох талаар учир дутагдалтай байдаг. Тэгвэл Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт: цувралын “Математик” ном нь хүний эрхийг математикийн хичээлд нэгтгэж өгснөөрөө энэ ойлголтыг таягдан хаяхад чухал ач холбогдолтой алхам боллоо.

Хүний Эрх Сургалтын Хөтөлбөрт: цувралын “Математик” ном нь Иргэншлийн боловсролын агуулга дахь хүний эрхийн бүхий л асуудлуудыг дунд сургуулийн математикийн хичээлийн агуулгад тусгаснаараа чухал ач холбогдолтой болсныг сургалтанд оролцогчид үнэлж байлаа.

Сургалтанд оролцогчид бидний сургалтыг чухлаар үнэлж цаашид бүх багш нарт энэ сургалтын үзэл санааг хүргэхийн төлөө ажиллахыг санал болгож байв.

Төслийн үр дүнд:

- Сургалтанд хамрагдсан нийт 460 гаруй багш нар хүний эрхийн боловсролын гарын авлага, материалаар хангагдлаа.
- Сургалтанд хамрагдагсад ХЭБ-ын талаархи мэдлэг чадвараа дээшлүүлж, эрхэд суурилсан боловсролын талаархи мэдлэг, чадварыг нэмэгдүүлснээр хүүхдийг хөгжилд хүргэх боловсролын таатай орчин бүрдүүлэхэд хувь нэмэр боллоо.
- Байгууллагын сургагч багш нарын чадавхи дээшилж, ЕБС-ийн багш нарт зориулсан ХЭБ-ын сургалтын хөтөлбөр боловсрогдлоо.



Эцэст нь манай төслийн хүрээнд хийгдэж байгаа сургалтууд нь багшийг хөгжүүлэх, тэдний сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, хүүхдэд эрхийн мэдрэмжийг хөгжүүлэх, хүний эрхэд тулгуурласан сургалтын таатай орчин бүрдүүлэхэд зохих хувь нэмэр боллоо гэж төслийн баг үнэлж байна.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДАД СУРГАЛТ ЯВУУЛАХ СУРГАГЧ БАГШ НАРЫН СУРГАЛТ



Энэ оны 8, 9 дүгээр саруудад галт зэвсэг хэрхэн хэрэглэх талаар цагдаа албан хаагч нарт сургалт явуулах сургагч багш

бэлтгэх сургалтыг зохион явууллаа. Энэхүү сургалт нь цагдаагийн алба хаагчдын хүний эрх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, албан үүргээ гүйцэтгэх үедээ шаардлагатай нөхцөлд тохирох хүч хэрэглэх, ингэхдээ үйл ажиллагааны алдаа гаргахгүй байх чадварыг нэмэгдүүлэхэд зорилгоо чиглүүлсэн юм.

Мөн Эмнести Интернэшнлээс Хүч ба галт зэвсгийг хэрэглэх талаар цагдаагийн албан хаагч болон албан хаагчдад хэрхэн сургалт явуулах тухай багш нарт зориулсан цуврал номыг хэвлүүлсэн билээ. Тус гарын авлагад тулгуурлан явуулсан сургалтад Эмнести Интернэшнл байгууллагын гишүүдээс гадна хуульч, хүний эрхийн мэргэжсэн сургагч багш нар болон цагдаагийн алба хаагч, судлаачид оролцсон юм. Сургалт хоёр үндсэн хэсгээс бүрдсэн бөгөөд эхний сургалтын агуулга нь цагдаа нарт хэрхэн галт зэвсгийг хуулийн хүрээнд хэрэглэх тухай байсан бол дараагийн сургалтад сургагч багш нарт цагдаагийн албан хаагчдын ажлын онцлог, сэтгэл зүйд тохируулан сургалт явуулах тухай байлаа. Сургалтыг “Хүч ба галт зэвсэг” цагдаагийн үйл ажиллагааны гарын авлагыг зохиогч докторант Б.Алтанбагана, Эмнести Интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа нар болон Боловсрол дээд сургуулийн багш доктор П.Одгэрэл, магистр Б.Уламбаяр, болон Эмнести Интернэшнлийн гишүүн, сэтгэл зүйч, докторант, бэлтгэгдсэн багш нар одоо тус гарын авлага болон сургалтын дагуу Дархан, Эрдэнэт, Төв аймгийн цагдаагийн газар болон Хан-уул дүүрэг, 801, 805-р ангиудын цагдаагийн алба хаагчдад сургалтуудыг явуулж эхлээд байна.

Сургалтыг зохион байгуулагчид энэхүү сургалт нь цагдаагийн алба хаагчдад тохиолддог ажлын онцлогтой холбоотой саад бэрхшээлийг даван туулах болон цагдаагийн хүч болон галт зэвсгийг хэрхэн хэрэглэх талаар дэлгэрэнгүй ойлголтыг өгөх үр дүнтэй ажил боллоо гэж үзэж байгаа юм.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ НЬ



Нийгмийн болон хувийн амьдрал эрх мэдлээ ашиглан албадан шахах эсвэл дур зоргоороо авирлаж эмэгтэйчүүдэд бие, сэтгэл, бэлгийн зовиур, хор хөнөөлөөр заналхийлж буй хүйсийн хүчирхийллийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэдэг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь тэдний нийгмийн гарал, арьс өнгө, нас, үндэс угсаа, шашин шүтлэг, тахир дутуу байдал, бэлгийн хандлага зэрэг бүх талыг хамран иргэншил, бүс нутаг, эдийн засгийн хил хязгаарт үл харъяалагдан оршдог. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь нэн ужиг гаралтай, гэмт хэргийн хамгийн адармаатай хэлбэр юм.

Эмнести Интернэшнл Олон Улсын Хүний Эрхийн байгууллага 2004 оныг “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооё” уриан дор үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулан Монгол дахь салбараас хэд хэдэн арга хэмжээг өөрийн оронд зохион байгуулж явуулсан юм.

Хууль эрх зүйн орчин ба хуулийн хэрэгжилтийн хяналт

Эмнести Интернэшнл байгууллагын үйл ажиллагааны нэгэн томоохон чиглэл нь олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрт улс орнуудыг нэгдүүлэх, үндэсний хууль тогтоомжийг түүнд нийцүүлэх, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих явдал билээ. Монгол улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах, хуулийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх талаар Эмнести Интернэшнлийн Монгол дахь салбар, Эрэгтэйчүүдийн холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй 2004-2005 онд хамтран ажилласан бөгөөд хамтран хэрэгжүүлсэн “Эр хүн эр хүндээ”, “Эргэх холбоо” төслийн дараагийн алхам болгож, хуулийн хэрэгжилтийн талаар энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийн санал бодлыг сонссон юм. Эмнести Интернэшнл байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга хурандаа Р.Оюунбадам “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль онол практикт” гэсэн сэдвээр илтгэл бичсэнийг The Wire сонингоороо дамжуулан уншигчдын хүртээл болголоо. Тэрээр Монгол улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг судлах, хэрэглэх тал дээр дутмаг байгааг дурдаад агуулга нь бүрхэг энэ хуулинд эрдэмтэн судлаач нар албан бус тайлбар хийх, Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар нэмэлт заалт оруулж өгмөөр байгааг ялангуяа гэр бүлийн хүчирхийллийг бодит байдлаар тогтоосон нөхцөлд эрүүгийн хариуцлага оногдуулдаг шүүхийн практикийг өөрчлөх саналыг бодит жишээн дээр тулгуурлан санал болгож байсан юм.

Мөн үүнээс гадна Гэр бүлийн тэмцэх хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг амьдрал дээр бодит болгох үүднээс Эмнести Интернэшнлийн хуульчдын бүлгийнхэн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрөөр өдөрлөг зохион байгуулж 40 орчим иргэдэд хуулийн үнэгүй зөвлөгөө өгч ажилласан ба энэ ажиллагааг 25 дугаар телевиз болон Зууны мэдээ сонинд нийтэлсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар өөрт байгаа мэдээлэл, хохирогчдын талаарх санал хүсэлтээ эмэгтэйчүүдийн энэ чиглэлээр ажилладаг байгууллагынхантай солилцож, тэднээс зохион байгуулж буй уулзалт, Азийн сан, Жендэр судлалын төв, Шведийн Институт болон ЮНИСЕФ-тэй хамтран зохион байгуулсан хурал, семинаруудад гишүүд, дэмжигчид, ажилчдаа оролцуулав.

Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн чиглэлээр гарын авлага танилцуулгыг хэвлэн гаргаж, цахим хуудсандаа “Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нь” сэдэвт судалгааг англи монгол хэл дээр байрлуулав. Энэ

Тус компани нь тэдний буруутай үйл ажиллагаанаас болж өвс ургамал нь хүмүүсийн аюулгүй байдал муугаар нөлөөлж буйг мэдсээр байж үр дүнтэй ажил хийгээгүй байна.

Улмаар иргэд ундны цэвэр ус хомсдох аюул тулгарсан авч тус компани хийгээд засгийн газрын зүгээс дорвитой арга хэмжээ аваагүй юм. Хэдийгээр Энэтхэгийн дээд шүүхээс Мадхья Прадеш мужийн удирдлагад энэ асуудлыг шийдвэрлэхийг даалгасан боловч цэвэр усаар хангах асуудал шийдэгдээгүй бөгөөд энэ нь цэвэр ус хангалттай хоол хүнсээр хангагдах хүний эрхийг зөрчсөн хэрг болж байгаа юм. Иймд Эмнести Интернэшнл байгууллагаас Мадхья Прадеш мужийн удирдлагад хандан захидал урилгыг илгээсэн юм.

Харин 2006 оны 2 дугаар сарын 20-нд 150 Бопал иргэд Энэтхэгийн ерөнхий сайдтай уулзаж эрхээ хангуулах талаар шаардлага тавин 900 км газрыг явган туулж Шинэ Дели хотноо иржээ. Үүний зэрэгцээ Эмнести Интернэшнлийн дэмжигчид, гишүүд цахим хуудсаар дамжуулан тэдний төлөө гарын үсэг цуглуулахад, хэдхэн 7 хоногийн дотор 4000 гаруй гарын үсэг цуглуулж чадсан билээ.



ЭРХЭЭ ХАМГААЛЖ ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ

Даян дэлхийн Эмнести Интернэшнлийн салбар бүр яг нэг цагт нэгэн зэрэг эхэлж, хэдэн зуун сая хүний гарын үсэгтэй захидлуудыг улс орны тэргүүн, шийдвэр гаргах түвшний хүмүүст илгээдэг энэ аян олон мянган хүнд итгэл найдвар, эрх чөлөө авчирч, хэдэн зуун хүний амь насыг аварч байсан билээ. Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр буюу Олон улсын хүний эрхийн өдрөөр Эмнести Интернэшнл байгууллага интернэт кафе болон хүнсний дэлгүүрүүдтэй хамтарч захидал уриалга бичих кампанит ажлаа зохион байгуулдаг билээ. Захидал уриалга бичих кампанит ажилд иргэдийг татан оруулах үүний ач холбогдолыг хүмүүст ойлгуулах үүднээс хэвлэлийн бага хурал хийлгэв.

2006 оныхоо марафоныг “Хүн байх эрх- Эрхээ эдэлж чадвал шоколад шиг амтагдана” уриан дор тэмдэглэн Скай худалдааны төв, Номин плаза, Номин Хайпер маркет, Номин их дэлгүүрийн салбар болон “Канион”, “Сайн уу дот ком” интернэт кафенууд дээр зохион байгуулав.

Эмнести Интернэшнлийн оюутан залуучуудын бүлгийн 22 идэвхтэн 6 баг болон өөр хоорондоо өрсөлдөн ажиллав.

Эмийн аюулгүй байдлын асуудлаар Монгол улсын эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, хүнсний аюулгүй байдлын асуудлаар Хүнс хөдөө аж ахуйн сайд Л.Тэрбишдагва, Энхийг сахиулах хүчнийг Дарфур руу оруулж, сүүлийн 4 сарын турш түр орогнох байр болон дүрвэгчдийн лагерьт амьдарч буй 2 сая гаруй иргэдийг хамгаалуулах асуудлаар Суданы эрх баригч нарт, Интернэтээр хүний эрх болон ардчиллын талаар мэдээлэл хайсан хэргээр баривчлагдаад буй 25 настай залууг суллуулахаар Вьетнамын Ерөнхий сайдад, терроризмын хэрэгт сэжиглэгдэн метронд буудуулж амь насаа алдсан Бразил иргэний асуудлаар Английн эрх баригч нарт, Эрүүдэн шүүж, хүнлэг бусаар харьцахыг таслан зогсоож, Гуантанамо Бэй дэх хорих байруудаа хаахыг уриалж АНУ-ын эрх баригч нарт, Конго улсаас цагаачлан ирэгсэдтэй зүй бусаар харьцаж хүч хэтрүүлэн хэрэглэж буй Испанийн хүчний байгууллагынхантай холбоотой асуудлаар Испанийн Дотоод хэргийн сайд нарт хандаж бичсэн захидал уриалгуудад нийт 4189 гарын үсгийг цуглууллаа.

Мөн энэ үеэр Эрхээ мэддэг хүн л эрхээ эдэлж чаддаг асуулт хариултын тэмцээн зохиогдож, хүний эрхтэй холбоотой 3 асуултанд хариулж чадсан хүн бүр эх орны үйлдвэрийн “Алтан говь шоколадаар шагнуулж байлаа. Шоколад амталсан тэдгээр хүмүүс “Эрхээ эдэлж чадвал шоколад шиг амтагдана” гэсэн танай уриа таалагдаж байна гэгцгэсэн юм. Мөн энэ үеэр захидлаа явуулахдаа дугтуй марк авч хэрэглээрэй хэмээн иргэд 10-төгрөгнөөс эхлээд 1\$ хүртэл мөнгө хандивласан байна.

Энэ өдөр болсон бас нэг онцлог явдал нь иргэн Б.Дагвасүрэн Скай худалдааны төв дээр явж байгаад

эрхээ хамгаалж бичигцгээ кампанит ажилд оролцож, улмаар өөрийн хувь нэмрийг оруулах зорилгоор тус байгууллагын төв дээр ирж “Урт насалж удаан жаргах монгол уламжлалт арга ухаан, ёс заншил, арга зүй” гэсэн номноосоо Монголын Эмнести Интернэшнл байгууллагад хандивлахын зэрэгцээгээр эрүүл мэнд нь үргэлж эрсдэлд байдаг хоригдлууд тэр дундаа эмэгтэй хоригдлуудад зориулан 5 хувь номыг хандивлаж, тэдэнд дамжуулж өгөхийг Эмнести Интернэшнл байгууллагаас хүслээ. Тэрээр “Саяхан би зурагтаар Дээд боловсрол, доод үнэ нэвтрүүлэг үзээд Монголын залуучууд ямар сүрхий болсныг олж харлаа. Та нар шиг ийм шижигнэсэн залуучууд монголын хүний эрхийн байдалд эерэг нөлөө авчирч чадна. Эрүүл байх, эрүүл мэндийн эрх гэдэг бол нэн чухал зүйл. Энэ эрхээ эдэлж чадсанаар маш олон эрх хамгаалагдаж чадна. Тимийээс би та нарт энэ номоо хандивлахаар ирлээ” хэмээн биднийг урамшуулсан юм. Ийнхүү захидал уриалга бичих аян Монгол улсад амжилттай зохиогдож өндөрлөлөө.



УЛС ОРНУУДЫН КАМПАНИТ АЖЛУУД

Залуучууд эмэгтэйчүүдийн эрхийн төлөө

Хүний сэтгэлийг цочирдуулж сэрдхийлгэсэн цэрэг дайны үйл хэрэгт эмэгтэйчүүд асар ихээр бие сэтгэлээрээ хохирдог юм. Тухайлбал Дэлхийн 2-р дайнаас өмнө буюу дайны үед Японы цэргүүд 200,000 гаруй охид эмэгтэйчүүдийг хүчирхийлэн, боолчилж байжээ. Тэд охид эмэгтэйчүүдийг эрүүдэн шүүж, хутгалах буюу тамхины галаар түлэх зэргээр тарчлааж байжээ. Өнөөдрийг хүртэл 50 гаруй жилийн турш тэдний ихэнх нь орчноос тусгаарлагдах зовлонг амсаж, хүнээс ичиж зовох, оюуны болон бие бялдарын хувьд эрүүл бус байдалтай аж төрөн амьдарцаж байна. Хамгийн сэтгэл эмзэглүүлэм зүйл гэвэл эдгээр хүмүүс хэзээ ч гэрлэх боломжгүй болсон явдал юм. Тэдгээрийн олонх нь бэлгийн замын өвчин, эрхтний гэмтлийн улмаас хүүхэд төрүүлэх боломжгүй болжээ.

1992 онд бэлгийн талаарх боолчлолын систем ба Японы засгийн газрын эдрээтэй төвөгтэй байдлыг нотолсон хөдлөшгүй баримт гарч ирсэн юм. Гэвч Япон улс олон улсын хуулийн дагуу хүлээсэн үүргийн дагуу хохирогчдоос уучлалт хүсэхээс татгалзсаар байна.

Одоогоор Японы засгийн газар “нөхөн төлбөрийн мөнгө” хуваарилан олгох нэрээр Азийн Эмэгтэйчүүдийн Сан байгуулсан хэдий ч түүхийн үнэнийг илэрхийлэхээс цааргалж байгаа юм. Энэ бүхнийг эсэргүүцэж Эмнести Интернэшнл Японы засгийн газарт хандан үнэнийг илэрхийлсэн мэдээллийг олон нийтэд түгээн албан ёсоор уучлал гуйх, мөн нөхөн олговор олгохыг шаардан уриалга гаргасан билээ.

2006 оны 8 дугаар сарын 9-нд Эмнести Интернэшнл байгууллагын залуучуудын бүлгийнхэн МУИС-ын өмнөх эрх чөлөөний талбайд “Энэ хэрэгт хэлмэгдэн хохирсон эмэгтэйчүүдээс уучлалт гуйх, Амьд үлдэгсэд болон тэдний гэр бүлийхэнд хангалттай тусламж үзүүлэх, Японы сурах бичгүүдэд дэлхийн II дайны бэлгийн боолчлолын талаархи үнэнийг өгүүлэх, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарч буй үед даруй мэдээлэх, ийм гэмт хэрэг дахин давтагдахгүй байх талаар олон улсын шүүхийн өмнө батлахыг шаардсан эрвээхэйн дүрст захидалд нийт 160 гаруй хүний гарын үсэг цуглуулсан юм.

Элчин сайдын яаманд айлчлал хийлээ

Эмнести Интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, кампанит ажлын зохицуулагч Э.Отгончулуун нар Япон улсын элчин сайдын нэгдүгээр нарийн бичгийн дарга Т.Ядомитай уулзсан юм. Уулзалтын үеэр Бэлгийн боолчлолд өртсөн эмэгтэйчүүдийн асуудлаар баримталж буй Японы засгийн газрын бодлого, энэ талаар хийгдэж буй ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ноён Т. Ядоми хийж, Монгол дахь Эмнести Интернэшнл

байгууллагын үйл ажиллагааны талаар сонирхон, өөрийн элчин сайдын яамнаас Монгол улсад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар тодорхой мэдээлэл өглөө.

Бэлгийн боолчлолд өртсөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж, Японы эрх баригч нарт хандан гаргасан уриалга бүхий 248 ил захидлыг Япон улсын ерөнхий сайдад илгээсэн бөгөөд мэдээллийг 2006 оны 10 дугаар сарын Японы ерөнхий сайдын айлчлалын үеэр Ардын эрх сонинд нийтэлсэн байна.

ОХУ-д хүний эрхийн байдал зөрчигдөж энгийн иргэд, хүний эрхийн төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүд, сэтгүүлчид, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэгсэд, засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандагсад хэн бүхэн эрх нь зөрчигдөж янз бүрийн дарамт шахалтын дор байсаар байна. Тэрчлэн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийн хэлбэрүүд түгээмэл байна. Энэ 2006 оны хувьд Эмнести Интернэшнл байгууллагаас ОХУ-ын эрх баригчдад хандан хэд хэдэн захидал уриалгыг илгээсэн юм.

Захидал уриалга

Аюулгүйн тусгай албаны ажилтан байсан хуульч Михайл Трепакшин 2004 оны 5 дугаар сард улсын нууц задруулсан, хууль бусаар зэвсэг авч явсан хэргээр 4 жил хоригдох ял авсан бөгөөд түүний хэргийг шүүх ажиллагаа улс төрийн зорилготойгоор шударга бус явагдсан юм.үүнийг Оросын хүний эрхийн байгууллагууд Михайл Трепакшины 1999 онд орон сууцанд бөмбөг дэлбэрсэн хэргийг мөрдөж байсныг нь таслан зогсоох гэсэн оролдлого гэж үзэж байсан юм. Гэвч одоо хүртэл түүнийг суллах байтугай хүнд нөхцөл бүхий хорих байранд хорьсоор байгаа юм.

Москва хотод барилга дэлбэрсэн хэргийг Чеченьчууд бус Оросын тагнуулын албад өөрсдөө хийсэн гэдгийг, хяналт шалгалт мөрдөн байцаалтын явцад олж тогтоосноо тайлагнасан оросын хуульч Михайл Трепакшиныг баривчлан хорьж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үзүүлэхгүй байгаад анхаарлаа хандуулж эмнэлгийн тусламж үзүүлэх, хэргийг нь шударга шүүхээр шийдвэрлэхийг уриалан ОХУ-ын эрх баригчдад хандан Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид гарын үсэг цуглуулан захидал уриалгыг илгээлээ.

Энэ оны 10 дугаар сарын 7-нд ОХУ-ын сэтгүүлч, хүний эрхийн төлөө тэмцэгч Анна Политковскаяг Москва хотод байрладаг гэрийнх нь гадна амийг нь хөнөөжээ. Аллага ОХУ дахь хүний эрхийн зөрчлийг зоригтойгоор ил гарган

